



2020 оны 08 дугаар сарын 26
№32 /1134/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Гэрээ соёрхон батлах
тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн
гишүүнээр томилох
тухай**

**Монгол Улс
олон улсын
гэрээ**

**Бүгд Найрамдах Франц
Улсын Засгийн газар болон
Монгол Улсын Засгийн газар
хоорондын санхүүгийн
хэлэлцээр**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | | |
|------|-------------------------------------------|--|------|
| 377. | Гэрээ соёрхон батлах тухай | | 1698 |
| 378. | Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай | | 1698 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|------------------------------------------------------|-----------|------|
| 379. | Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр
томилох тухай | Дугаар 86 | 1698 |
| 380. | Шүүгчийн бүрэн эрхийг
түдгэлзүүлэх тухай | Дугаар 88 | 1699 |
| 381. | Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай | Дугаар 89 | 1699 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--------------------------------|-----------|------|
| 382. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 96 | 1700 |
| 383. | Дүрэм шинэчлэн батлах тухай | Дугаар 97 | 1711 |

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | | |
|------|----------------------------------------------------------------------------------------------------------------|--|------|
| 384. | Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс
болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам
Улс хоорондын гэрээ | | 1747 |
| 385. | Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар
болон Монгол Улсын Засгийн газар хоорондын
санхүүгийн хэлэлцээр | | 1759 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хооронд 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийн Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 18, Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Дашнямын Цогтсайханыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 06 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдсон тул Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Дашнямын Цогтсайханы шүүгчийн бүрэн эрхийг 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн шүүгч Лодойн Цэрэндуламыг Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.5, Монгол хэлний тухай хуулийн 11.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн дэмжлэгээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 196 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2020 оны
96 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III

Нэг. Ерөнхий мэдээлэл

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн, албан ёсны сонгодог төдийгүй дэлхийн бичиг соёлын нандин өв юм.

Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг юм.

1946 оноос хойш төрийн албан хэргийг кирилл бичгээр хөтлөн явуулж байгаа ч төрийн байгууллагын тамга, тэмдгийг монгол бичгээр үйлдэн хэрэглэж, иргэний болон боловсролын бичиг баримтыг кирилл болон монгол бичгээр зэрэгцүүлэн бичиж байгаа нь монгол бичиг төрийн хэрэгт зохих үүргээ гүйцэтгэсээр байгаагийн нэгэн бодит жишээ болно.

Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I”, 2008-2015 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II”-ийг тус тус хэрэгжүүлсэн. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, II” хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон.

Гэвч “Бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох” зэрэг зорилтууд хангалтгүй хэрэгжиж иржээ.

Өнөөгийн монгол бичгийн сургалт, хэрэглээний нөхцөл байдалд хийсэн шинжилгээний дүнгээр цаашид монгол бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэхэд технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Мөн Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлохдоо “монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх” гэж, мөн хуулийн 7.2-т “Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж, 24.2-т “Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж тус тус заасан нь энэхүү хөтөлбөрийг шинэчлэн батлуулах эрх зүйн үндэслэл болж байна.



Иймд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлэхэд боловсрол, соёл, шинжлэх ухаан, мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн салбарын бодлогын зорилтуудыг цогц байдлаар уялдуулж, шинээр авч үзэх нь энэ хөтөлбөрийг боловсруулах нийгмийн хэрэгцээ, нэгэн чухал хүчин зүйл болсон байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1.2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, бэлтгэлийг бүрэн хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1.монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх;

2.2.2.монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх;

2.2.3.албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах;

2.2.4.монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох.

2.3.Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1.Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.монгол бичгийн кодчиллол, стандартыг боловсронгуй болгож, олон улсын жишигт хүргэх;

3.1.2.албан хэргийг кирилл, монгол бичгээр хөтлөх стандартыг боловсруулж батлуулах;

3.1.3.монгол бичгийн үндэсний нэгдсэн цахим хуудас (порталсайт) нээж, хэрэглээг тогтмолжуулах;

3.1.4.нийгмийн сүлжээнд монгол бичгээ хэрэглэх технологийг нэвтрүүлж, контентын төрөл, хэлбэрийг олшруулах;



3.1.5.суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнийг шинэлэг арга зүйгээр боловсруулж гаргах;

3.1.6.цахим хичээл, цахим сурах бичиг, толь бичиг, сургалтын хэрэгсэл боловсруулж, нэвтрүүлэх;

3.1.7.цахим орчинд монгол бичгээр бичвэр боловсруулах чиглэлийн мэргэшүүлэх сургалтыг эрчимжүүлэх;

3.1.8.монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт дурсгалуудыг хамгаалах, хэвлэн нийтлэх, олшруулах;

3.1.9.утга зохиолын бүтээлийг монгол бичгээр хэвлэхийг дэмжих;

3.1.10.“Төрийн мэдээлэл” сэтгүүлийг 2021 оноос эхлэн хос бичгээр хэвлэж, 2023 оноос зөвхөн монгол бичгээр хэвлэх бэлтгэл хангаж, хэрэгжүүлэх;

3.1.11.монгол бичгээр дагнан гардаг сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн тоог нэмэгдүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх;

3.1.12.тогтмол хэвлэл мэдээллийн байгууллага сонин, сэтгүүл, нийтлэл, мэдээллийн агуулгын 30-аас доошгүй хувийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн гаргах, номын нэрийг нуруу хэсэгт монгол бичгээр бичиж хэвшүүлэх;

3.1.13.албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, нэрийн хуудас, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлэх;

3.1.14.Монголын үндэсний олон нийтийн телевизийн дэлгэцийн бичвэрийг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн бичих ажлыг эхлүүлэх.

3.2.Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын бүсийн зөвлөгөөнийг 2 жилд тутам, улсын зөвлөгөөнийг 4 жил тутам зохион байгуулах;



3.2.2.бүх нийтийн монгол хэл, бичгийн хэрэглээ, хандлага, үнэлэмжийн судалгаанд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл, арга замыг тодорхойлох;

3.2.3.Боловсролын хүрээлэнгийн бүтцэд монгол бичгийн сургалт, судалгаа, арга зүйн нэгж ажиллуулах;

3.2.4.ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн монгол хэл, монголын түүх, уран зохиол, иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийн сурах бичгийг нэн түрүүнд, бусад хичээлийн сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар монгол бичигт хөрвүүлэн хэвлэх;

3.2.5.монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийг нягт уялдуулан заах арга зүйн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх;

3.2.6.хилийн чанадад амьдарч байгаа монгол иргэд, хүүхэд, залууст монгол бичгийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх эрх зүйн болон материаллаг орчин бүрдүүлэх;

3.2.7.Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн сургуульд монгол хэл, бичгийн хичээлийг заавал судлах эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.8.багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн ангид монгол бичиг заах аргын хичээлийг тусгайлан оруулах;

3.2.9.ерөнхий боловсролын сургууль төгсөгчид монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгөх, шалгалтын тестийн монгол бичгийн агуулгыг 30-аас доошгүй хувьд хүргэх, шалгалтын босго оноог 400-аас эхлүүлж цаашид тодорхой хугацаанд үе шаттай нэмэгдүүлэх;

3.2.10.2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах;

3.2.11.их, дээд сургуульд суралцагчдаас монгол бичгийн чадварын шалгалт заавал авч, дүнг бакалаврын дипломд баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3.2.12.монгол бичиг заах арга зүй, технологийг шинэчлэн боловсруулах;

3.2.13.монгол бичгийн улсын олимпиадыг жил бүр зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, 2021 оноос эхлэн хэрэгжүүлэх;



3.2.14.монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих;

3.2.15.байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян, хөдөлгөөн өрнүүлэх.

3.3.Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.Төрийн албаны зөвлөл, Хэлний бодлогын үндэсний зөвлөл хамтран төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварын түвшин тогтоох шалгалтын агуулгыг тогтоож, баталгаажуулах;

3.3.2.төрийн албан хаагчийн анкет (маягт-1)-д монгол бичгээр унших бичих чадварыг тэмдэглэх хэсгийг нэмэх;

3.3.3.төрийн албанд анх орох иргэдийн монгол хэл, бичгийн шалгалтын 20-аас доошгүй хувь нь монгол бичгийн агуулгаас бүрдсэн байх;

3.3.4.төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагад монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусгах;

3.3.5.төрийн байгууллагууд байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын сургалтын хөтөлбөрт ажилтны монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг жил бүр төлөвлөх, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж тайлагнах;

3.3.6.төрийн болон хувийн хэвшлийн байгууллага бүр монгол хэл, бичгийн хянан найруулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах;

3.3.7.төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх;

3.3.8.хөтөлбөрийн холбогдох арга хэмжээг бүх шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулан хэрэгжүүлж, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд санаачилга, үр дүнтэй ажилласан төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, ажилтан, иргэдийг урамшуулах.

3.4.Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



3.4.1.монгол бичиг, сурвалж судлалыг монгол судлалын бие даасан чиглэл болгож, онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх;

3.4.2.монгол бичгийн сургалт, арга зүй, судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулах;

3.4.3.монгол хэл, бичгийн дурсгал, соёлын өвийг хамгаалах, сургалтад хэрэглэх, судлан түгээх төслүүдийг Шинжлэх ухаан, технологийн сан болон бусад эх үүсвэрээс жил бүр санхүүжүүлэх;

3.4.4.монгол бичгийн өв, үндэсний соёл сэтгэлгээг хадгалах, хамгаалах, хөгжүүлэх үндэсний сан байгуулах;

3.4.5.монгол бичгийн контентыг төрийн бодлогоор дэмжиж, нэр төрлийг олшруулах;

3.4.6.монгол бичиг сурч судлах, түгээн дэлгэрүүлэхэд иргэд, олон нийтийн идэвхийг өрнүүлэх, үндэсний аяныг зохион байгуулах;

3.4.7.насан туршийн боловсролын төвд албан бус сургалтаар иргэдэд монгол бичиг сургахыг дэмжих;

3.4.8.үндэсний хэмжээнд монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжих;

3.4.9.гадаадад монгол бичгийг сурталчлах, монгол уран бичлэг, монгол бичгээрх өв соёлын үзэсгэлэн зохион байгуулах, монгол иргэд, хүүхэд залууст монгол бичиг сургах үйл ажиллагааг Монгол Улсаас гадаад орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд, Монгол судлалын төвүүд дэмжин ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2020)	Зорилтот түвшин	
					2022 онд	2024 онд
1 дүгээр зорилт. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх						
1.	Монгол бичгийн кодчилол, стандартыг олон улсын жишигт хүргэн боловсронгуй болгож батлуулна.	Батлагдсан монгол бичгийн кодчилол, стандартын тоо	тоо	-	1	-



2.	Цахим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нэвтрүүлэг, нийтлэл, мэдээллийнхээ 30-аас доошгүй хувийг монгол бичгээр тогтмол хөтлөн явуулна.	Нийтлэл мэдээллийн 30-аас доошгүй хувийг монгол бичгээр хөтөлж байгаа байгууллагын тоонд эзлэх хувь	хувь	0.3	20	30
3.	Монгол бичгийн үндэсний нэгдсэн цахим хуудас (порталсайт) нээж, цахим сурах бичиг, толь бичиг, цахим хичээл сургалтын хэрэгсэл, хөрвүүлэх програм нэвтрүүлнэ.	Цахим сан	тоо	-	1	-
		Цахим толь бичиг	тоо	-	1	-
		Хөрвүүлэгч програм	тоо	-	1	2
		Цахим хичээл	тоо	-	1	5
4.	“Төрийн мэдээлэл” сэтгүүлийг 2020 оноос эхлэн хос бичгээр хэвлэнэ.	Монгол бичгээр зэрэгцүүлсэн агуулгын эзлэх хувь	хувь	-	30	100
5.	Монгол бичгээр дагнан гардаг сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн тоог нэмэгдүүлнэ.	Тогтмол хэвлэлийн тоо	тоо	-	2	4
6.	Цахимд монгол бичгээр бичвэр боловсруулах чиглэлийн мэргэшүүлэх сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан ажилтан/иргэдийн тоо	тоо	-	2000	2500
7.	Албан байгууллага, аж ахуй нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, нэрийн хуудас, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлнэ.	Албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийн судалгааны маягтын тоо	тоо	-	1	-
		Нэр, хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан байгууллагын эзлэх хувь	хувь	5	80	100
2 дугаар зорилт. Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүрэх						
1.	Боловсролын хүрээлэнгийн бүтцэд монгол бичгийн судалгаа, арга зүйн нэгж ажиллуулна.	Байгуулагдсан нэгжийн тоо	тоо	-	1	-



2.	Монгол хэл, бичгийн багш нарын онол, заах арга зүйн төвлөрсөн болон бүсчилсэн сургалт зохион байгуулна.	С у р г а л т а д хамрагдсан багш нарын нийт монгол хэлний багш нарт эзлэх хувь	хувь	-	50	100
3.	Монгол хэл бичгийн сургалтын чанарын үнэлгээнд дунд ахлах анги төгсөгчдийг хамруулна.	Суурь, бүрэн дунд б о л о в с р о л ы н төгсөх ангийн сурагчдын тоонд эзлэх хувь	хувь	-	100	100
4.	Монгол бичиг заах арга зүй, технологийг шинэчлэн нэвтрүүлнэ.	Багш нарт түгээсэн заах аргагүйн т е х н о л о г и й н гарын авлага, зөвлөмжийн тоо	тоо	-	2600	3000
5.	Бүх шатны б о л о в с р о л ы н с у р г а л т ы н б а й г у у л л а г ы н монгол бичгийн хичээлийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний аргачлалыг шинэчлэн баталж, хэрэгжүүлнэ.	Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэвлүүлж түгээсэн тоо	тоо	-	4000	5000
		Үнэлгээний аргачлалыг баталгаажуулсан баримт бичиг	тоо	-	1	-
6.	2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах нөхцөл бүрдүүлнэ.	Монгол бичгийн хичээл судалдаг их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн хувь	хувь	-	50	80
3 дугаар зорилт. Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах						
1.	Албан бичгийг хос бичгээр хөтлөх стандарт батлагдсан байна.	Батлагдсан стандартын тоо	тоо	-	1	-



2.	Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг шалгах, үнэлэх, дээшлүүлэх эрх зүйн орчин, тогтолцоо бий болгосон байна.	Төрийн албан хаагчийн анкетын тодорхой хэсэгт нэмэлт оруулах	хувь	-	-	100
		Төрийн албаны ерөнхий шалгалтын үнэлгээнд монгол бичгийн мэдлэг, чадварыг оноогоор үнэлэх зохицуулалт	хувь	10	-	20
		Монгол бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь	хувь	-	50	70
3.	Төрийн байгууллагад албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулах эрх зүй, технологийн нөхцөл бүрдүүлнэ.	Хос бичгээр албан хэрэг хөтлөх журмыг туршсан байгууллагын тоо	тоо	-	10	50
		Монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдсан бичиг хэргийн ажилтны тоо	тоо	-	500	1000
4 дүгээр зорилт. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох						
1.	Монгол бичгийн судалгааны ажил, төсөл хөтөлбөрийг төрөөс дэмжинэ.	Улсын захиалгат төсөл, санхүүжилтийн дүн	тоо	-	1	2
2.	Монгол бичгийн цахим контентыг төрийн бодлогоор дэмжиж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	Хэрэглээнд нэвтрүүлсэн цахим контентын төрөл, тоо	тоо	-	5	10
3.	Орон нутагт монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр өрнүүлсэн аян, арга хэмжээ, урамшуулал.	Арга хэмжээний тоо	тоо	-	22	30
4.	Насан туршийн боловсролын төвүүдэд монгол бичиг заах сургалтын эрх зүйн орчин бүрдүүлнэ.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	тоо	-	1500	5000



5.	Гадаадад монгол бичгийг сурталчлах үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	тоо	-	10	15
----	------------------------------------------------------------------------------	--------------------	-----	---	----	----

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2.гадаадын зээл, тусламж;

5.1.3.олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;

5.1.5.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

5.2.Төрийн байгууллагууд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж хэрэгжүүлэх бөгөөд түүний хэрэгжилтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн холбогдох үйл ажиллагааг төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд тусгаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газарт танилцуулна.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, хөтөлбөрийн үр дүнг Засгийн газрын баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

6.3.Хэвлэл мэдээллийн байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийг энэ журмын 6.2-т заасан журмын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тайлагнана.



6.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур зүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийг 1 дүгээр хавсралт, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийг 2 дугаар хавсралт, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 263 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Ц.ДАВААСҮРЭН

Засгийн газрын 2020 оны
97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр цахилгаан эрчим хүч хэрэглэхтэй холбогдуулан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “үйлдвэрлэгч”, “дамжуулагч”, “түгээгч”, “хангагч” гэх) болон хэрэглэгч иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулна.



1.2.Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, дэд станц, шугам тоноглолыг өмчлөгч, эзэмшигч, хэрэглэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.3.Цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор дамжуулах, түгээх сүлжээнд шинээр холболт хийх, цахилгаан ачааллыг нэмэгдүүлэх, цахилгаан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох бүрт иргэн, хуулийн этгээд техникийн нөхцөл авна.

1.4.Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл хүссэн хүсэлтээ цахим системээр гаргах бөгөөд 1 мегавольт-ампер (цаашид “МВА” гэх) болон түүнээс дээш цахилгаан ачаалалтай эсхүл цахилгаан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох техникийн нөхцөлийн хүсэлтийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 1 МВА-аас бага цахилгаан ачаалалтай тохиолдолд техникийн нөхцөлийн хүсэлтийг түгээгч, хангагч эсхүл дамжуулагч тус тус шийдвэрлэнэ.

Хоёр. Иргэн, хуулийн этгээдэд цахилгаан сүлжээнд холбох техникийн нөхцөл олгох

2.1.Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл хүссэн хүсэлтээ дараах баримт бичгийн хамт ирүүлнэ. Үүнд:

2.1.1.хүсэлт гаргасан этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.1.2.газрын эрхийн гэрчилгээний болон кадастрын зургийн хуулбар;

2.1.3.техникийн нөхцөл олгох барилга байгууламжийн архитектурын төлөвлөлтийн даалгавар, загвар зураг;

2.1.4.шаардлагатай ачааллын тооцоо (хүчин чадлыг МВА-аар илэрхийлэх);

2.1.5.хувийн өмчийн цахилгаан шугам сүлжээнээс холболт хийх тохиолдолд тухайн шугам сүлжээний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл.

2.2.Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох тохиолдолд энэ дүрмийн 2.1-д заасан баримт бичгээс гадна эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны

төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн шийдвэр, Диспетчерийн үндэсний төвийн тухайн жилийн горимын тооцоог тус тус хавсаргана.

2.3. Дараах тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг ажлын хэсгээр хэлэлцүүлэхгүйгээр 2 хоногийн дотор буцаана:

2.3.1. газрын маргаантай, газрын эрхийн гэрчилгээ, баталгаажсан кадастрын зураг, хүсэлт, бусад баримт бичгийн эзэмшигчийн нэр зөрүүтэй;

2.3.2. шаардсан бичиг баримтын бүрдэл дутуу.

2.4. Иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг энэ дүрмийн 1.4-т заасан байгууллагын ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

2.5. Ажлын хэсгийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр, түгээгч, хангагч, дамжуулагчид гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр тус тус байгуулж, ажиллах журмыг батална.

2.6. Ажлын хэсэг техникийн нөхцөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ дараах саналыг үндэслэнэ:

2.6.1. тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, дамжуулах, түгээх сүлжээний техникийн боломжийн талаарх хангагч байгууллагуудын санал;

2.6.2.5 МВА болон түүнээс дээш цахилгаан ачаалалтай тохиолдолд эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох талаарх Диспетчерийн үндэсний төвийн тухайн жилийн горимын тооцоо, хангагч байгууллагуудын санал;

2.6.3. цахилгаан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох тохиолдолд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн шийдвэр, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл, Диспетчерийн үндэсний төвийн тухайн жилийн горимын тооцоо, хангагч байгууллагуудын санал.

2.7. Ажлын хэсэг техникийн нөхцөл олгохдоо цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм, цахилгаан техникийн байгууламжийн



угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм болон дараах шаардлагыг баримтална:

2.7.1.нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зоорийн эсхүл нэгдүгээр давхарт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй тохиолдолд орон сууцны тэжээлийн кабель хэт ачаалагдахгүй байх нөхцөлийг хангаж байвал 10.0 киловольт-ампер (цаашид “кВА” гэх) хүртэл суурилагдсан хүчин чадалтай 3 фазын цахилгаан тоног төхөөрөмжийг тухайн орон сууцны ерөнхий щитнээс, хэрэв суурилагдсан хүчин чадал нь 10.0 кВА-аас дээш эсхүл 10.0 кВА-аас бага боловч тэжээлийн кабель хэт ачаалагдахаар байвал ойролцоох дэд станцаас шугам татаж тус тус холбоно;

2.7.2.0.4-35 киловольт (цаашид “кВ” гэх)-ын сүлжээнээс холбоход тухайн шугамын нэвтрүүлэх чадвар, дэд станцын трансформатор, тоноглолын хүчин чадал хүрэлцэхгүй эсхүл шугамын трасс, дэд станцын хийцийг өөрчлөх тохиолдолд гарах зардал (үнийн зөрүү, холбогдох үйлчилгээний төлбөр)-ыг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцах бөгөөд тухайн тоног төхөөрөмж нь түгээгчийн өмчлөлд хэвээр үлдэнэ. (Энэ заалт нь хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний дагуу байрласан гэр хорооллын газар эзэмших эрх бүхий иргэдэд хамаарахгүй);

2.7.3.шугамын дундаас холбогдох тохиолдолд тухайн шугамын трассыг өөрчилж, өөрийн дэд станцаар оруулж гарган тэжээгдэхээр бол тухайн шугамыг түгээгчийн өмчлөлд шууд шилжүүлэх, харин дэд станцын ашиглалт, засварын зардлыг тухайн иргэн, хуулийн этгээд хариуцах ба хэрэв тухайн ашиглалт, засварын зардлыг иргэн, хуулийн этгээд хариуцахгүй хангагч хариуцах тохиолдолд шинээр баригдсан шугам, дэд станцыг үнэ төлбөргүй хангагч байгууллагад шилжүүлнэ;

2.7.4.шинээр дэд станц, шугам тоноглол холбуулж байгаа иргэн, хуулийн этгээд нь дамжуулагч, түгээгч, хангагчийн өмчлөлд байгаа шугам, дэд станцыг өргөтгөсөн бол тухайн дэд станц, шугам тоноглолын өмчлөл хэвээр үлдэнэ;

2.7.5.суурилагдсан нийлбэр хүчин чадал нь 40.0 кВА-аас дээш байх иргэн, хуулийн этгээд өөрийн трансформаторын дэд станц барьж байгуулж болно. Хэрэв тухайн нутаг дэвсгэрийг цахилгаанаар хангаж байгаа 6 (10) кВ-ын хүчдэлийн гол шугам, 35, 110 кВ-ын хүчдэлийн трансформаторын хүчин чадал нь хүрэлцэхгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн хэтийн төлөвтэй уялдуулан шийдвэрлэнэ;

2.7.6.гэр хорооллын айл өрхийн 10.0 кВА хүртэл суурилагдсан нийлбэр хүчин чадалтай 0.22 кВ, 0.4 кВ-ын хүчдэлийн 3 фазын цахилгаан тоног төхөөрөмжийг холбох асуудлыг түгээгч хариуцна.



2.8.Техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хүлээн авснаас хойш эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түгээгч, хангагч, дамжуулагч 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ. Хүсэлт гаргагч нь өөрийн хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар цахим системээр мэдээлэл авч болно.

2.9.Техникийн нөхцөлийг гүйцэтгэх ажлын хэмжээнээс хамааруулж 2 жил хүртэл хугацаагаар олгоно. Хугацааг нэг удаа 1 жилээр сунгаж болно.

2.10.Иргэн, хуулийн этгээдэд олгох техникийн нөхцөлд дараах зүйлийг тусгана. Үүнд:

2.10.1.техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг;

2.10.2.техникийн нөхцөл хүссэн байршил;

2.10.3.ажил, үйлчилгээний зориулалт;

2.10.4.олгосон буюу суурилагдсан хүчин чадал;

2.10.5.тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага;

2.10.6.гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага;

2.10.7.холбогдох цэг (дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцын нэр, өргөтгөл хийх хэсгийн хүчдэлийн түвшин, шугамын төрөл, дэд станцын хүчин чадал);

2.10.8.шинээр холболт хийх, ачаалал нь нэмэгдсэнтэй холбогдуулан дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага;

2.10.9.реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага;

2.10.10.реактив чадлын зохицуулалт;

2.10.11.цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ;

2.10.12.техникийн нөхцөлийн тусгай заалт хэсэгт нэмэлт шаардлага (ижил маягийн цахилгаан тоног төхөөрөмж, тоноглол суурилуулах, цаашид ухаалаг сүлжээ үүсгэх боломж зэрэг)-ыг тусгах;

2.10.13.цахилгаан тоног төхөөрөмжийн нэг маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж;

2.10.14.хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжид тавих тусгай шаардлага (гэнэтийн гэмтэл саатал, аваарын үед ашиглах бэлтгэл



тэжээлийн схем, хэрэглэх цахилгааны бие даасан үүсгүүр (цахилгаан эрчим хүчний суурин (хангагчийн) үүсгүүрээс хамааралгүйгээр хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр тэжээх боломжтой үүсгүүр) гэх мэт);

2.10.15.хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны байдал;

2.10.16.сүлжээ төлөвлөлт, горимын онцгой ач холбогдол бүхий нийтийн сүлжээ, магистрал шугам үүсгэхээр хэсэгт иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр дэд станц, шугам тоноглол барих шаардлага гарч, техникийн нөхцөл олгох тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тухайн дэд станц, шугам, тоноглолыг шилжүүлэх талаар техникийн нөхцөлд тодорхой заах;

2.10.17.техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа;

2.10.18.дагаж мөрдөх хууль, дүрэм, журам.

2.11.Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн өмчлөл, эзэмшлийн цахилгаан сүлжээнд 1 МВА хүртэл хүчин чадалтай техникийн нөхцөл олгох тохиолдолд дамжуулагчаас холбогдох саналыг авсан байна.

2.12.Техникийн нөхцөлийн шаардлагыг иргэн, хуулийн этгээд, зураг төслийн байгууллага, гүйцэтгэгч болон холбогдох бусад байгууллага биелүүлэх үүрэгтэй.

2.13.Захиалагч иргэн, хуулийн этгээд нь барилга угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төслөө зураг төслийн байгууллагатай хамтран олгосон техникийн нөхцөлийн дагуу холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

2.14.Хангагч, түгээгч, дамжуулагч нь зураг төслийг техникийн нөхцөл, зураг төслийн шийдэл, холбогдох норм, дүрмийн шаардлагыг хангасан байдлыг ажлын 10 хоногийн дотор хянаж, сүлжээнд холбогдох боломжтой эсэхийг мэдэгдэнэ. Нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол хянах хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.

2.15.Дараах тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохоос татгалзана. Үүнд:

2.15.1.эх үүсвэр, холбогдох цэгийн хүчин чадал хүрэлцэхгүй;

2.15.2.шинээр барих, зөөх дэд станц, шугамын трасс нь тухайн орон нутгийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдахгүй, тухайн орчинд нийтийн зориулалт бүхий цахилгаан сүлжээ үүсгэх боломжийг хаасан эсвэл хаах тохиолдолд;



2.15.3.тухайн нэгдсэн сүлжээний чадал нэвтрүүлэх болон шингээх чадвар хүрэлцэхгүй, горим ажиллагааны хувьд ажиллах боломжгүй бол;

2.15.4.цахилгаан эрчим хүчний найдваржилтийн I зэрэглэлийн хэрэглэгчийн эрчим хүчний тасралтгүй ажиллагааг хангахад хүндрэл учруулж болзошгүй тохиолдолд;

2.15.5.Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан болон Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу цахилгаан, дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчилтэй бол.

2.16.Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-т заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ.

2.17.Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

2.17.1.хүчинтэй хугацаа дууссан;

2.17.2.техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

2.17.3.холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;

2.17.4.дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.

2.18.Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл шинээр авах, сунгуулах, цахилгаан сүлжээнд холбуулахад эрх бүхий этгээдээс тогтоосон үйлчилгээний төлбөр (хураамж) төлнө.

2.19.Техникийн нөхцөлийг үндэслэл муутай олгосноос учирсан хохирлыг энэ дүрмийн 1.4-т заасан уг техникийн нөхцөлийг олгосон этгээд хариуцна.

Гурав. Иргэн, хуулийн этгээдийн шинээр барьсан цахилгаан тоног төхөөрөмжийг сүлжээнд холбох

3.1.Иргэн, хуулийн этгээдийн захиалгаар гүйцэтгэгчийн шинээр барьсан буюу шинэчилж өөрчилсөн цахилгаан тоног төхөөрөмж нь цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм, цахилгаан



техникийн байгууламжийн угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм болон барилгын норм, дүрэм, өгөгдсөн техникийн нөхцөлийн шаардлагыг бүрэн хангасан байвал зохино.

3.2.Захиалагч нь холболт хийхийн өмнө эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээг тус цахилгаан тоног төхөөрөмжийн гүйцэтгэгчтэй хамтран шинэ цахилгаан тоног төхөөрөмжид холбогдох дүрмийн дагуу туршилт, сорилт хийж, акт, протокол үйлдэнэ.

3.3.Захиалагч, хангагч, дамжуулагч буюу түгээгчийн төлөөлөл бүхий комисс нь шинээр барьсан буюу шинэчилж өөрчилсөн цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг энэ дүрмийн 3.2-т заасан акт, протоколын дагуу газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргах бөгөөд хангагч нь цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг хийсний дараа цахилгаан тоног төхөөрөмжийг хүчдэлд залгах зөвшөөрлийг хэрэглэгчид олгоно.

3.4.Энэ дүрмийн 3.3-т заасан зөвшөөрлийг үндэслэж, дамжуулагч буюу түгээгч нь хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийг сүлжээнд холбож хүчдэлд залгана. 35 кВ-аас дээш хүчдэлтэй шугам, дэд станцыг залгах тохиолдолд нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу сүлжээнд холбож хүчдэлд залгана.

3.5.Энэ дүрмийн 2.10, 3.1-т заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын ажил дутуу хийгдсэн эсхүл энэ дүрмийн 2.12, 2.13, 4.1, 4.2-т заасан шаардлага хангагдаагүй байвал сүлжээнд холбохгүй.

Дөрөв. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ

4.1.Хангагч нь иргэн, хуулийн этгээдтэй Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ (цаашид “гэрээ” гэх) байгуулснаар иргэн, хуулийн этгээд нь цахилгаан эрчим хүч хэрэглэх эрхээр хангагдана.

4.2.Иргэнтэй байгуулах гэрээнд (зөвхөн ахуйн хэрэгцээнд цахилгаан эрчим хүч хэрэглэх тохиолдолд) Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан асуудлыг тусгана.

4.3.Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд энэ дүрмийн 4.2-т зааснаас гадна дараах асуудлыг тусгана:

4.3.1.хэрэглэгчийн зэрэглэл, зэрэглэлийг хангах техникийн боломж (бэлтгэл тэжээл, бэлтгэл тэжээлийг автоматаар залгагч, цахилгааны бие даасан үүсгүүр);



4.3.2.цахилгаан сүлжээнд хэрэглэгчийн холбогдсон хүчин чадал (цахилгаан шугам сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн нийт трансформатор болон 1000 вольт (цаашид “В” гэх)-оос дээш хүчдэлийн цахилгаан хөдөлгүүрийн нийлбэр чадлыг буюу 1000 В хүртэл хүчдэлийн сүлжээнээс авах зөвшөөрөгдсөн чадал), хэрэглэх эрчим хүчний хэмжээ;

4.3.3.цахилгааны төлөвлөгөөт таслалт, гэмтэл зөрчил, төлбөр тооцооны тухай мэдээллийг хүлээн авах хангагч, хэрэглэгчийн хаяг, утасны дугаар;

4.3.4.төлбөр тооцооны хэлбэр.

4.4.Энэ дүрмийн 4.3-т заасан нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд хэрэглэгч нь 3 хоногийн дотор зохих өөрчлөлтийг тусгаж, хангагчаар хянуулсан байх шаардлагатай.

4.5.Хангагчаас шаардлагатай гэж үзвэл хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд дараах зүйлийг нэмж тусгана:

4.5.1.захиалсан дээд чадал (техникийн нөхцөлийн дагуу олгосон чадлын дээд хэмжээ);

4.5.2.энэ дүрмийн 8.1-д заасны дагуу реактив чадлыг зохицуулах тариф;

4.5.3.цахилгаан тоног төхөөрөмжид шуурхай ажиллагааны үйлчилгээ үзүүлэх эрх бүхий ажилтан (түгээгч ба хэрэглэгч)-тай харилцах журам.

4.6.Хэрэглэгч нь дараах баримт бичгийг хангагчаар хянуулж, гэрээнд хавсаргасан байна:

4.6.1.цахилгаан шугам сүлжээний эзэмшлийн зааг (үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгчийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өмчлөл, эзэмшлийн харьяаллаар нь хуваан зааглаж байгаа цэг);

4.6.2.хэрэглэгчийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээний бүдүүвч, техникийн өгөгдөл;

4.6.3.хангагчтай зөвшилцсөн ажиллагааны горим, хамгаалалтын болон автоматикийн хэрэгслийн тавил;

4.6.4.тооцооны хэмжих хэрэгсэл (төлбөрийг тооцох зорилгоор хэрэглээг тооцох цэг дээр байрлуулсан цахилгааны тоолуур,



чадлын хэмжүүр, тэдгээрт холбогдсон хэмжүүрийн трансформатор болон холболтын хэрэгсэл)-ийн байршил, өгөгдөл;

4.6.5.эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг (хэрэглэгчид түгээсэн цахилгаан эрчим хүчний хэмжээг тодорхойлох зорилгоор цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд тооцооны хэмжих хэрэгслийг холбосон цэг) хүртэлх шугамын алдагдлыг тодорхойлох томьёо (гаргалгааны хамт);

4.6.6.Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11-д заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжөөр дамжуулан бусад хэрэглэгчид цахилгаан эрчим хүч дамжуулсан үйлчилгээний төлбөрийн хэмжээ. Үйлчилгээний төлбөрийг тогтоохдоо тухайн хэрэглэгчийн ашиглах цахилгаан тоног төхөөрөмжийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг баримтална.

4.7.Цахилгаан тоног төхөөрөмжийн байршил, нэр, дугаар, гүйдэл, хүчдэлийн трансформатор, тооцооны тоолуур, зааг, байршил зэргийг тодотгож, гүйцэтгэлийн зургийг хийж, шугам сүлжээний эзэмшлийн заагийг дараах байдлаар тогтооно:

4.7.1.агаарын болон кабель шугамын эхний, эцсийн холболтоор;

4.7.2.трансформаторын дэд станц дэх самбарын шинийн холболтоор;

4.7.3.трансформаторын гаргалгаан дээрх холболтоор;

4.7.4.хуваарилах самбарын салгуурын үл хөдлөх хэсгийн холболтоор;

4.7.5.ил хуваарилах байгууламжийн хөндлөвч дээрх холболтоор.

4.8.Шугам сүлжээний эзэмшлийн заагийн холболтын бүрэн бүтэн байдлыг дор дурдсаны дагуу хариуцна:

4.8.1.эзэмшлийн зааг нь агаарын шугам, ил хуваарилах байгууламжийн хөндлөвч дээр байвал уг хөндлөвч, гол агаарын шугамыг эзэмшигч;

4.8.2.эзэмшлийн зааг нь дэд станц, хуваарилах самбарын дотор байвал уг дэд станц, самбарыг эзэмшигч;

4.8.3.дундын өмчлөлийн орон сууцны ерөнхий щитний тэжээлийн оролтын кабелийн холболтыг түгээгч.



4.9.Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүчний тарифт орох өөрчлөлтийн талаар Эрчим хүчний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасны дагуу хэрэглэгчид мэдэгдсэний дараа хангагч, хэрэглэгч гэрээндээ өөрчлөлт оруулна. Гэрээнд өөрчлөлт оруулаагүй нь өөрчлөгдсөн тарифыг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

4.10.Өмчлөгчтэй байгуулсан батлан даалтын гэрээг үндэслэж хангагч нь түүний байранд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, хашаа, орон сууцанд нь түр оршин суугч иргэнтэй гэрээ байгуулж болно. Хэрэв ийнхүү батлан даалтын гэрээ байгуулаагүй бол цахилгаан эрчим хүчний хангамжийн өмчлөгчтэй байгуулсан гэрээгээр зохицуулна.

4.11.Хангагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

5.1.Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа цахилгаан тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх хүрээнд дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

5.1.1.өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжлийн зэрэгтэй ажилтныг томилох;

5.1.2.хангагчаас шалтгаалж цахилгаан эрчим хүч тасалдсан, чанарын стандартын шаардлага хангаагүй цахилгаан эрчим хүчээр хангасан тохиолдолд энэ талаар хангагчид тухай бүр шуурхай мэдэгдэх, хохирлоо барагдуулахыг шаардах;

5.1.3.өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, хамгаалах багаж хэрэгсэлд ашиглалтын үеийн үзлэг үйлчилгээ, засвар, урьдчилан сэргийлэх ээлжит туршилтыг зохих норм, дүрмийн дагуу тогтоосон хугацаанд мэргэжлийн байгууллага, ажилтнаар хийлгэх;

5.1.4.хангагчаас зөвшөөрсөн хэрэглэгчийн сүлжээний горим болон реле хамгаалалт, автоматикийн тавил, хугацааг мөрдөх;

5.1.5.цахилгаан тоног төхөөрөмжийн байрыг аваар ослоос урьдчилан сэргийлэх, гал түймэр эсэргүүцэх хэрэгслээр хангах;

5.1.6.цахилгаан тоног төхөөрөмж хариуцсан ажилтныг хамгаалах багаж хэрэгсэл, угсралт, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, гарын авлагаар хангаж, холбогдох сургалтад хамруулсан байх;



5.1.7.цахилгаан станц, шугам сүлжээнд аваар гарсан тохиолдолд тухайн хэрэглэгчийн цахилгаан ачааллыг бууруулах талаар дамжуулагч, түгээгч, хангагчийн шийдвэрийг биелүүлэх;

5.1.8.хяналтын болон хангагч байгууллагын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх;

5.1.9.хангагчийн шаардлагаар ачааллын хэмжилт хийж, дүнг мэдээлэх (ахуйн хэрэглэгчид хамаарахгүй);

5.1.10.хуулийн этгээд нь жил бүрийн 7 дугаар сарын 20-ны дотор дараа жилийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг хангагчид гаргаж өгөх;

5.1.11.иргэн өөрийн сууц, гараж, хашаа, туслах аж ахуйн болон зуслангийн байшингийн цахилгаан шугам, дотоод холболт, цахилгаан хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах;

5.1.12.хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн зохицуулалттай хангалтын төлбөрийн тарифаас хангагчтай тооцоо хийх тарифыг сонгох;

5.1.13.дараахь нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай дамжуулагч, түгээгч, хангагчид шуурхай мэдээлэх:

5.1.13.1.тооцооны хэмжих хэрэгсэлд эвдрэл, гэмтэл гарсан буюу гарч болзошгүй болсон;

5.1.13.2.тэжээлийн шугам таслагдаж хүчдэлгүй болсон, цахилгаан гүйдэлд хүн, амьтан нэрвэгдсэн буюу нэрвэгдэх нөхцөл бүрдсэн;

5.1.13.3.хэрэглэгчийн нутаг дэвсгэр, орчин тойронд байрлах хангагчийн мэдлийн цахилгаан тоног төхөөрөмжид гэмтэл гарсан буюу гарч болзошгүй болсон.

5.1.14.Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг хэрэгжүүлж өөрийн эзэмшлийн газарт байгаа цахилгаан тоног төхөөрөмжийг хамгаалах, тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, кабелийн болон агаарын шугамын хамгаалалтын зурваст газар шорооны болон бусад ажлыг хангагч эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хийлгэхгүй байх;

5.1.15.бусад хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдаж, учирсан хохирлыг хангагч төлсөн тохиолдолд буруутай хэрэглэгч уг төлбөрийг хангагчид төлөх;

5.1.16.өөрийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээ, дамжин нэвтрүүлэх дэд станцад байгаа цахилгаан тоног төхөөрөмжид засвар хийхдээ сүлжээнээс таслах, сүлжээнд залгахыг түгээгч, хангагч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэх;

5.1.17.нутаг дэвсгэртээ байгаа дэд станц, хуваарилах байгууламж, шугам сүлжээнд сэлгэн залгалт, үзлэг үйлчилгээ, засвар хийхээр ирсэн дамжуулагч, түгээгч, хангагчийн ажилтныг саадгүй нэвтрүүлэх;

5.1.18.төрийн ёслол, олон улсын шинжтэй уулзалт, тэмцээн зэрэг арга хэмжээг зохион явуулах үед цахилгаан хангамжийн найдвартай байдлыг онцгойлон анхаарах, 3-аас доошгүй хоногийн өмнө хангагчид албан ёсоор мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх;

5.1.19.улирлын шинжтэй ажилладаг цахилгаан тоног төхөөрөмжид хангагчаар үзлэг хэмжилт хийлгэж шалгуулсны үндсэн дээр сүлжээнд залгуулах;

5.1.20.өөрийн эзэмшлийн цахилгаан тоноглолыг дотоод хэт хүчдэл, аянгын хэт хүчдэлээс хамгаалах тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад байлгах;

5.1.21.хүнд үйлдвэрүүд (төмөрлөгийн үйлдвэрүүд гэх мэт) нь дээд гармоникийг хязгаарлах зориулалт бүхий тоног төхөөрөмж (реактор гэх мэт) хүчин чадалд тохируулан суурилуулж, хангагч байгууллагаар дүгнэлт гаргуулж, ашиглах.

Зургаа. Тооцооны хэмжих хэрэгслийн ашиглалт

6.1.Цахилгаан эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тооцох зорилгоор хэрэглэгч бүрт тооцооны хэмжих хэрэгсэл тавьсан байна.

6.2.Цахилгаан эрчим хүчний зарцуулалтад дотоод хяналт тавих зорилгоор шаардлагатай нэгж, хэсэг болон цахилгаан тоног төхөөрөмжид хэрэглэгч өөрөө хяналтын хэмжих хэрэгсэл (хянах зориулалтаар тухайн сонгосон цэг дээр байрлуулсан цахилгааны тоолуур, чадлын хэмжүүр, тэдгээрт холбогдсон хэмжүүрийн трансформатор болон холболтын хэрэгсэл) тавьж болно.

6.3.Актив, реактив цахилгаан эрчим хүчний тооцооны хэмжих хэрэгсэл (тоолуур, хэмжүүрийн трансформатор гэх мэт)-ийг эрх олгогдсон этгээдийн лабораторид засвар, тохируулга хийж, эрх бүхий байгууллага шалгаж битүүмжилсэн байна.



6.4.Тооцооны хэмжих хэрэгсэл, тэдгээрийн холболтын сүлжээ нь нэг щит, хайрцагт байрласан байвал зохино. Щит буюу хайрцгийг битүүмжилж, өндөрт хөдөлгөөнгүй байрлуулж, газардуулсан байна.

6.5.Хэрэглэгч нь стандарт болон цахилгаан тоног төхөөрөмжийн угсралтын дүрмийн шаардлага хангасан щит, хайрцаг хэрэглэнэ.

6.6.Щит, хайрцаг нь дараах иж бүрдэлтэй байна:

- 6.6.1.оролтын салгуур;
- 6.6.2.цахилгаан эрчим хүчний тоолуур;
- 6.6.3.тоолуурын холболтын цуглуулга;
- 6.6.4.хэмжүүрийн трансформатор (шаардлагатай бол);
- 6.6.5.ачаалалд тохирсон автомат буюу гал хамгаалагч.

6.7.Тооцооны 220 В-ын нэг фазын болон 380 В-ын гурван фазын индукцийн цахилгаан тоолуурт 3 жил, 100 В-ын гурван фазын индукцийн цахилгаан тоолуурт 3 жил, 100 В-ын гурван фазын импульсын тоолуурт 4 жил, нэг болон гурван фазын электрон тоолуурт 8 жил, нэг болон гурван фазын импульсийн тоолуурт 4 жил, гүйдлийн трансформаторт 4 жил, хүчдэлийн трансформаторт 4 жилд нэг удаа тус тус ээлжит баталгаажуулах шалгалт хийнэ.

6.8.Тооцооны хэмжих хэрэгслийг тэжээж байгаа хэмжүүрийн трансформаторыг солих, тооцооны тоолуурыг салгах, тавих ажлыг зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр түгээгч гүйцэтгэнэ. Тооцооны тоолуурыг сүлжээнээс салгах, холбох үед хэрэглэгчийн төлөөлөгчийг байлцуулна.

6.9.Тооцооны хэмжих хэрэгслийг тэжээж байгаа гүйдэл, хүчдэлийн трансформаторын салгуурын бариул, түүний холболтын цуглуулгыг байрлуулсан щит, хайрцаг, тоолуурын таглаа зэргийг хангагчийн эрх бүхий ажилтан битүүмжилсэн байна.

6.10.Хэрэглэгчийг төлбөр тооцооны хэмжих хэрэгслээр хангах, түүнийг баталгаажуулах, засварлах, солих, тоолуурыг холболтын цэгт суурилуулахтай холбогдон гарах зардлыг өмчлөгч хариуцна.

6.11.Шинээр ашиглалтад орох орон сууц, барилга байгууламжид хангагчийн олгосон техникийн нөхцөлд болон техникийн шаардлагад заасан тоолуурыг барилгын захиалагч, гүйцэтгэгч байгууллага тавих ба хангагчийн эрх бүхий ажилтнаар хэлхээг шалгуулан битүүмжлэл тавина.

6.12.Тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг уг хэмжих хэрэгслийг эзэмшигч иргэн, хуулийн этгээд хариуцна.

6.13.Хангагч, хэрэглэгчийн хооронд тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагаатай холбогдон гарсан маргааныг хэмжил зүйн эрх бүхий улсын байцаагч шийдвэрлэнэ.

6.14.Дамжуулах сүлжээний дэд станцаас шууд тэжээгдэж байгаа хэрэглэгчийн тоолуур болон түүний хэмжих хэрэгслүүдийг хэрэглэгч, түгээгч, дамжуулагчийн тусгай лацаар баталгаажуулж, хамтарсан протокол үйлдэнэ.

6.15.Дамжуулах сүлжээний дэд станцаас шууд тэжээгдэж байгаа хэрэглэгчийн тоолуур болон түүний хэмжих хэрэгслүүдийн хэвийн, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор хэрэглэгч, дамжуулагч нь ашиглалтын гэрээ байгуулж, ажиллана.

Долоо. Төлбөр тооцооны журам

7.1.Тооцооны хэмжих хэрэгслийг дамжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина.

7.2.Энэ дүрмийн 7.1-д заасны дагуу эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформатор (ачааллын болон хоосон явалтын) дахь алдагдлыг шугам сүлжээг эзэмшигч хүлээнэ.

7.3.Энэ дүрмийн 7.2-т заасны дагуу алдагдал хүлээдэг үндсэн хэрэглэгчийн цахилгаан сүлжээгээр дамжин холбогдсон хэрэглэгч уг алдагдлаас өөрийн хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний хэмжээнд ногдох хувийг хариуцна.

7.4.Хангагч, хэрэглэгчийн хооронд хийх тооцоог хэмжих хэрэгслийн заалт (бусад тохиолдолд энэ дүрмийн 7.5 дугаар заалт)-ыг үндэслэж, мөрдөж байгаа үнэ тарифын дагуу бодно.

Цахилгаан тоолуур нь гүйдэл ба хүчдэлийн трансформатортой дамжин холбогдсон байвал хэрэглэсэн эрчим хүчний хэмжээг тоолуурын одоогийн болон өмнөх заалтын ялгаврыг трансформаторын итгэлцүүрээр үржүүлж тодорхойлно.

7.5.Хэрэглэгчийн буруугаас шалтгаалж тооцооны хэмжих хэрэгсэл нь энэ дүрмийн 6.3, 6.9-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тооцоог хийхдээ хэрэглэгчид суурилагдсан чадлыг ажиллавал зохих цаг (сүүлийн удаа шалгалт хийснээс хойш тухайн зөрчлийг арилгах хүртэлх)-аар үржүүлж тодорхойлно.



7.6.Тооцооны хэмжих хэрэгсэл нь энэ дүрмийн 6.3, 6.9-д заасан шаардлагыг хангаагүй нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлахаар сүлжээнээс тасалсан тохиолдолд өмнөх 3 сард хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний дунджийг баримталж төлбөрийн тооцоог хийнэ.

7.7.Тооцооны хэмжих хэрэгсэл нь гадны нөлөөгөөр гэмтсэн, түүний холболт болон байршлыг өөрчилсөн зэрэг тохиолдолд сэргээн засварлах зардлыг буруутай этгээд, харин ашиглалтын үед гэмтсэн тохиолдолд өмчлөгч хариуцна.

7.8.Тооцооны хэмжих хэрэгслийг сэргээн засварлах, хэвийн ажиллагаанд оруулах ажлыг түгээгч, дамжуулагч 7 хоногийн дотор хийж үүрэгтэй.

7.9.Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийдэг ажилтны буруугаас гарсан зөрүүг хангагч, хэрэглэгч хоёр тал хамтран үйлдсэн актын үндсэн дээр дараа сарын тооцоонд тусгана.

7.10.Хэрэглэгч нь тухайн байрнаасаа түр буюу бүрмөсөн нүүх, байраа бусдад шилжүүлэх тохиолдолд энэ тухайгаа хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоог хийж дуусгах үүрэгтэй.

7.11.Байр, орон сууц, хашаа, газар өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд нүүхдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тооцоогоо хийж дуусгаж, энэ тухай тодорхойлолтыг хангагчаас авсан байна.

7.12.Энэ дүрмийн 7.11-д заасан тодорхойлолтыг тухайн байр, орон сууц, хашаа, газрыг шинээр өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд шаардаж авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй тохиолдолд шинээр өмчлөгч, эзэмшигч эрчим хүчний өрийг хариуцна.

7.13.Хангагч нь хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний төлбөрийг сард нэгээс доошгүй удаа хянан тооцоолно. Тоолуурын заалт авах хугацааг гэрээгээр зохицуулна.

7.14.Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчний тооцоог урьдчилан төлөх (хэрэглэгч нь төлбөрийн баталгаа болгож цахилгаан эрчим хүчний хэрэглээний төлбөрийн тодорхой хувийг урьдчилан байршуулсныг) хэлбэрээр хийж болно.

7.15.Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний тооцоог буруу гэж үзвэл энэ тухай хангагчид албан ёсоор мэдэгдэнэ. Хангагч мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор маргааныг шийдвэрлэнэ.



7.16.Хэрэглэгч нь хангагчийн энэ дүрмийн 7.15-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Эрчим хүчний тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Найм. Хэрэглэгчийн реактив чадлын зохицуулалт

8.1.Үйлдвэрлэлийн томоохон (холбогдсон чадал нь 250 кВА ба түүнээс дээш, реактив чадал нь холбогдсон чадлын 10-аас доошгүй хувь байх) хэрэглэгчид реактив тоолуурыг тооцооны зориулалтаар дараах тохиолдолд тавина. Үүнд:

8.1.1.эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх хэсэгт реактив цахилгаан эрчим хүчний үйлчлэлээр алдагдах цахилгаан эрчим хүчний хэмжээг тодорхойлох;

8.1.2.хэрэглэгчийн конденсатор, синхрон хөдөлгүүрийг хангагчаас тогтоосон горимоор ажиллуулж байгаа эсэхийг хянах.

8.2.Хэрэглэгч нь конденсатор, синхрон хөдөлгүүрийг эрх бүхий байгууллагаас олгосон техникийн нөхцөлийн дагуу цахилгаан шугам сүлжээнд суурилуулна. Тэдгээрийн ажлын горимыг хангагч, хэрэглэгч зөвшилцөн тогтооно.

8.3.Хангагч, түгээгч, дамжуулагч, хэрэглэгч нь Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан Хэрэглэгчдийн чадлын итгэлцүүр (COSφ)-ээс хамааруулж төлбөр тооцох журмыг мөрдөнө.

Ес. Хангагчийн эрх, үүрэг

9.1.Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

9.1.1.Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд цахилгаан эрчим хүчний хангамжийг халаалтын улиралд 4 цагаас илүү хугацаагаар таслахгүй байх;

9.1.2.хэрэглэгчийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжид Эрчим хүчний тухай хуулийн 32.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх;

9.1.3.үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгчийн өмчлөл, эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам сүлжээнд ноцтой осол гэмтэл гарсан үед Эрчим хүчний тухай хуулийн 6.1.4-т заасан журмыг баримтлан хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хангамжийг зохицуулах;



9.1.4.хангагчийн эрх бүхий ажилтныг томилох;

9.1.5.цахилгаан сүлжээнд холбох, таслах, холболтыг өөрчлөх тухай хэрэглэгчийн захиалгыг судлан үзэж, техникийн нөхцөлийн шаардлага хангасан гэж үзвэл 3 хоногийн дотор шийдвэрлэн уг ажлыг зохих төлбөртэйгөөр гүйцэтгэх;

9.1.6.улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар нийтийн эрх ашгийн үүднээс хийгдэж байгаа инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлыг саатуулсан иргэн, хуулийн этгээдийг эрчим хүчээр хангахгүй, хязгаарлах, хохирлыг төлүүлэх, техникийн нөхцөл олгохгүй байх.

9.2.Хангагчийн эрх бүхий ажилтан нь Эрчим хүчний тухай хууль, гэрээнд тусгагдсан дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

9.2.1.хэрэглэгчийн эрчим хүчний тооцоог сар бүр газар дээр нь шалгаж хянах;

9.2.2.хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалгах;

9.2.3.гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох, алданги тооцох, нөхөн тооцоололт хийх;

9.2.4.тооцооны хэмжих хэрэгслийн битүүмжлэлийг шалгаж, баталгаажуулалтаас бусад битүүмжлэлийг шинэчлэх, сэргээх.

Арав. Хохирлыг тооцох, нөхөн төлөх

10.1.Цахилгаан эрчим хүч тасалдсан, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс үүссэн хохирлыг тогтоохдоо хэрэглэгчид тавигдсан өөрөө бичигч хэмжих хэрэгсэл болон түгээгчийн шуурхай ажиллагааны бичлэгийг баримталж, хангагч, хэрэглэгчийн хамтран үйлдсэн актыг үндэс болгоно.

10.2.Энэ дүрмийн 10.1-д заасан актыг ажлын 5 хоногийн дотор гаргаж, актад цахилгаан эрчим хүч тасалдсан, хэлбэлзсэн он, сар, өдөр, үргэлжилсэн хугацаа, шалтгаан, үйлдвэрлэл, үйлчилгээнд учруулсан шууд хохирол (цахилгаан хангамж тасалдсан, чанарын үзүүлэлт хэлбэлзсэнээс хэрэглэгчид учирсан бүтээгдэхүүний чанарын гологдол, цахилгаан хэрэгслийн гэмтэл)-ын хэмжээ, хангагч, хэрэглэгчийн төлөөлөгчийн нэр, албан тушаалыг тодорхой тусгаж, гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

10.3.Актаар тогтоосон хохирлыг 1 сарын дотор буруутай тал хариуцан төлнө.

10.4.Цахилгаан эрчим хүч тасалдсанаас учирсан хохирлыг дараах тохиолдолд хангагч хариуцахгүй. Үүнд:

10.4.1.байгалийн гэнэтийн аюул (аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэт) тохиолдсон;

10.4.2.хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан;

10.4.3.Эрчим хүчний тухай хуулийн 29.1.2, 32.2-т заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан хангамжийг тасалсан, түдгэлзүүлсэн.

10.5.Орон сууцны ерөнхий щит, магистрал шугам, давхар дундын щитэнд гарсан гэмтлээс шалтгаалсан болон засвар үйлчилгээ хийгээгүйгээс үүдэн гарах хохирлыг тухайн шугам тоноглолыг хариуцагч хариуцна.

Арван нэг. Хяналт, хариуцлага

11.1.Энэ дүрмийн биелэлтэд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан, ажилтан, мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч хяналт тавина.

11.2.Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрчим хүчний хангамж, чанар, мөрдөж байгаа үнэ тарифын үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

11.3.Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.4.Хангагч, хэрэглэгч талууд хоорондоо зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй цахилгаан эрчим хүчний хангамж, хэрэглээтэй холбогдсон маргааныг Эрчим хүчний тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Засгийн газрын 2020 оны
97 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр дулааны эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдуулан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “үйлдвэрлэгч”, “дамжуулагч”, “түгээгч”,



“хангагч” гэх) болон хэрэглэгч иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулна.

1.2.Энэ дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.3.Дулааны эх үүсвэр барих, өргөтгөх, дулаан хангамжийн системд барилга байгууламж шинээр холбох, барилгын дулааны ачааллыг нэмэгдүүлэх бүрт иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл авна.

1.4.Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл хүссэн хүсэлтээ цахим системээр гаргах бөгөөд 1 гигакалор/цаг (цаашид Гкал/цаг гэх) болон түүнээс дээш дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 1 Гкал/цагаас доош дулааны ачаалалтай техникийн нөхцөлийг үйлдвэрлэгч эсхүл дамжуулагч, түгээгч, хангагч тус тус шийдвэрлэнэ.

1.5.Дулаан түгээх шугам сүлжээг барихад гаргасан хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэн уг шугам сүлжээний эзэмшлийн заагийг өмчийн харьяаллаар тогтооно.

1.6.Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч, хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтыг бүрэн хариуцаж, үзлэг үйлчилгээ, засвар шинэчлэлийг өөрийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллага, ажилтнаар гүйцэтгүүлнэ.

Хоёр. Иргэн, хуулийн этгээдэд дулааны шугам сүлжээнд холбох техникийн нөхцөл олгох

2.1.Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл хүссэн хүсэлтээ дараах баримт бичгийн хамт ирүүлнэ. Үүнд:

2.1.1.хүсэлт гаргасан этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.1.2.газрын эрхийн гэрчилгээний болон кадастрын зургийн хуулбар;

2.1.3.техникийн нөхцөл олгоход шаардагдах барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг;

2.1.4.шаардлагатай дулааны ачааллын тооцоо (Гкал/цаг);



2.1.5.хувийн өмчийн дулааны шугам сүлжээнээс холболт хийх тохиолдолд тухайн шугам сүлжээний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл.

2.2.Дулааны эх үүсвэр барих, өргөтгөх тохиолдолд энэ дүрмийн 2.1-д заасан баримт бичгээс гадна эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн шийдвэрийг хамтад нь ирүүлнэ.

2.3.Иргэн, хуулийн этгээдийн техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг энэ дүрмийн 1.4-т заасан байгууллагын ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

2.4.Ажлын хэсгийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр, үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагчид гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр тус тус байгуулж, ажиллах журмыг батална.

2.5.Ажлын хэсэг техникийн нөхцөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ дараах саналыг үндэслэнэ. Үүнд:

2.5.1.тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, дулааны эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний техникийн боломж;

2.5.2.5 Гкал/цаг болон түүнээс дээш ачаалалтай дулааны хэрэглээ болон эх үүсвэрийг төвлөрсөн дулаан хангамжид холбох талаарх Диспетчерийн үндэсний төвийн горимын тооцоо, үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч байгууллагуудын санал;

2.5.3.дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх тохиолдолд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн шийдвэр, Диспетчерийн үндэсний төвийн горимын тооцоо, үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч байгууллагуудын санал.

2.6.Техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ. Хүсэлт гаргагч нь өөрийн хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар цахим систем болон бусад хэлбэрээр мэдээлэл авч болно.

2.7.Техникийн нөхцөлийг гүйцэтгэх ажлын хэмжээнээс хамааруулж 2 жил хүртэл хугацаагаар олгоно. Хугацааг нэг удаа 1 жилээр сунгаж болно.



2.8.Иргэн, хуулийн этгээдэд олгох техникийн нөхцөлд дараах зүйлийг тусгана:

2.8.1.техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг;

2.8.2.барилгын байршил, мэдээлэл;

2.8.3.холбогдох цэг (дулааны эх үүсвэр, дулаан дамжуулах төв, дулаан дамжуулах, түгээх шугам, худаг), гадна агаарын тооцоот температур, дулаан зөөгчийн тооцоот температур, холболтын цэг дэх статик даралт, температурын график;

2.8.4.шинээр холбох, дулааны ачаалал нь нэмэгдсэнтэй холбогдуулан дулааны эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээ, тоноглол, дулаан дамжуулах төвийг өргөтгөх шаардлага;

2.8.5.дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, хэрэглээ;

2.8.6.тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага;

2.8.7.хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмжид тавих тусгай шаардлага (хими, ус цэвэрлэгээний төхөөрөмж, даралт, температур тохируулах төхөөрөмж, нөөц цахилгааны эх үүсвэр, нөөц тоног төхөөрөмж суурилуулах гэх мэт);

2.8.8.зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлага;

2.8.9.холбогдох цэгийн байршлын зураг, схем;

2.8.10.дагаж мөрдөх хууль, дүрэм, журам.

2.9.Техникийн нөхцөлийн шаардлагыг иргэн, хуулийн этгээд, зураг төслийн болон холбогдох бусад байгууллага биелүүлэх үүрэгтэй.

2.10.Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-т заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ.

2.11.Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

2.12.Захиалагч иргэн, хуулийн этгээд нь зураг төслийн байгууллагатай хамтран барилга угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төслөө холбогдох байгууллагуудаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж, баталгаажуулсан байна.

2.13.Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч болон магадлал хийх эрх бүхий байгууллага нь зураг төслийг техникийн нөхцөл, холбогдох норм, дүрмийн шаардлагыг хангасан байдлыг ажлын 10 хоногийн дотор хянаж, сүлжээнд холбогдох боломжтой эсэхийг зохих үндэслэлтэйгээр мэдэгдэнэ.

Нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол энэ хугацааг ажлын 14 хоног сунгаж болно.

2.14.Иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл шинээр авах, сунгуулахад эрх бүхий этгээдээс тогтоосон үйлчилгээний төлбөр (хураамж) төлнө.

2.15.Техникийн нөхцөлийг үндэслэлгүй олгосноос учирсан хохирлыг уг техникийн нөхцөлийг олгосон энэ дүрмийн 1.4-т заасан этгээд хариуцна.

Гурав. Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмжийг дулааны шугам сүлжээнд холбох

3.1.Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөлийн шаардлага бүрэн хангагдсан нөхцөлд шинээр барьсан буюу өргөтгөл, шинэчлэл хийсэн барилга байгууламжийг дулааны шугам сүлжээнд холбоно.

3.2.Иргэн, хуулийн этгээд нь дулааны шугам сүлжээнд барилга байгууламжаа холбуулахад дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1.үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагчийн заасан хугацаанд багтааж тухайн шугам сүлжээнээс холбогдвол зохих салаа шугамын холболт (огтолгоог)-ыг хийсэн байх;

3.2.2.дулааны шугам, тоног төхөөрөмжид угаалт, даралтын туршилт хийхдээ холбогдох үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагчийн төлөөлөгчийг байлцуулан акт үйлдсэн байх;

3.2.3.шалгаж баталгаажуулсан хянах хэмжих хэрэгсэл, автомат тохируулагчийг зураг төсөлд заасан цэгт тавих;

3.2.4.дулааны шугам, тоног төхөөрөмжийг хэсэгчлэн хүлээн авсан акт, гагнуурын болон далд ажлын акт, техникийн бусад баримт бичгийг бүрдүүлсэн байх;



3.2.5. шинээр барьсан барилга байгууламж, дулааны шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, холбогдох байгууллагын мэдээллийн санд бүртгүүлсэн актыг үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагчид ирүүлсэн байх.

3.3. Техникийн нөхцөл, хянасан зураг төслийн дагуу бариагүй барилга байгууламжийг дулаанаар хангахгүй.

3.4. Зам талбайг сэтэлж, дулааны шугам тавьсан тохиолдолд түүнийг тухайн этгээдийн зардлаар сэргээн засаж, хуучин байдалд нь оруулсны дараа дулааны шугам сүлжээнд холбох зөвшөөрлийг олгоно.

3.5. Иргэн, хуулийн этгээд нь дулааны шугам сүлжээнд шинээр холбох зөвшөөрөл авахад эрх бүхий этгээдээс тогтоосон үйлчилгээний төлбөр (хураамж) төлнө.

Дөрөв. Дулааны эрчим хүчээр хангах гэрээ

4.1. Хангагч нь энэ дүрмийн 3.1, 3.2-т заасан шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээдтэй Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу дулааны эрчим хүчээр хангах гэрээ (цаашид “гэрээ” гэх) байгуулж, дулааны эрчим хүчээр хангана.

4.2. Гэрээ байгуулахаас өмнө иргэн, хуулийн этгээд нь дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн засвар үйлчилгээг иж бүрэн хийж, зохих даралтаар шалган акт тогтоож, гүйцэтгэлийн бичиг баримт бүрдүүлсэн байна.

4.3. Энэ дүрмийн 4.2-т заасан актыг үндэслэж, хангагчтай дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулснаар дулааны эрчим хүч хэрэглэх эрхтэй болно.

4.4. Иргэнтэй байгуулах гэрээнд Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан зүйлийг тусгана.

4.5. Хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасан зүйлийг тусгана.

4.6. Хангагч нь хэрэглэгчид дулааны эрчим хүчийг уур, усаар тоолуургүй нийлүүлсэн тохиолдолд төлбөр тооцоо хийхдээ зураг төсөлд заасан дулааны ачааллыг үндэс болгоно.

4.7. Хэрэглэгч нь энэ дүрмийн 6.1.15-д заасны дагуу мэдээлэл авснаас хойш 15 хоногийн дотор хангагчтай байгуулсан гэрээнд өөрчлөлт

оруулна. Гэрээнд өөрчлөлт оруулаагүй нь түүнийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

4.8.Хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулах болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.

4.9.Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч, хэрэглэгч нь жил бүр тогтоосон халаалтын улирал дуусахад гэрээг дүгнэж, тооцоо нийлэн акт үйлдэж, халаалтын улирал эхлэх хугацаанд гэрээг шинэчлэн байгуулна.

4.10.Энэ дүрмийн 4.9-д заасны дагуу гэрээ дүгнэж, акт үйлдэхэд хэрэглэгч нь гэрээний үүрэг, техникийн шаардлагуудыг хангалттай биелүүлсэн тохиолдолд гэрээг 2 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

4.11.Хангагчийн үүргийн биелэлтийг дүгнэхдээ түүний нийлүүлсэн эрчим хүчний хэмжээ, чанарыг гэрээнд заасан хэмжээ, чанарын үзүүлэлттэй харьцуулна.

4.12.Дулаан зөөгч (уур, усны)-ийн даралт, температурын хэлбэлзлийн зөвшөөрөгдөх хэмжээг гэрээнд тусгахдаа техник ашиглалтын дүрмийг баримтална.

4.13.Хангагчаас олгосон техникийн нөхцөлийн дагуу өөрийн эзэмшлийн дулааны шугам, тоноглолоос шинээр хэрэглэгч холбуулахгүй тохиолдолд дулааны эрчим хүчээр хангахгүй.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

5.1.Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа дулааны тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

5.1.1.дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварыг хариуцах мэргэжлийн ажилтантай байх, түүнийг мэргэжлийн бус этгээдэд хариуцуулахгүй байх, мэргэжлийн ажилтны мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх;

5.1.2.дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ажлын зураг төсөл, гүйцэтгэлийн зураг, ашиглалтын паспорт зэргийг бүрдүүлж, жил бүр баяжилт хийх;



5.1.3.дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ээлжит их болон урсгал засварыг дамжуулагч, түгээгчийн төв шугамын засвартай уялдуулж, хугацаанд нь чанартай гүйцэтгэх;

5.1.4.засварын дараа хангагчийн төлөөлөгчийг байлцуулж, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээндээ химийн болон механик угаалга, цэвэрлэгээ, даралтын туршилт хийж, илэрсэн гэмтлийг засварлан хамтарсан акт үйлдэх;

5.1.5.дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд тохируулга хийж, барилга, орон сууцны өрөө тасалгааг жигд халаах нөхцөлийг хангах;

5.1.6.барилга орон сууцыг халааж байгаа сүлжээний усыг бүрэн хэмжээгээр буулгах тохиолдолд хангагчаас зөвшөөрөл авах, сүлжээний усыг юлэх болон бусад зориулалтаар ашиглахгүй байх;

5.1.7.өөрийн болон хамтын эзэмшлийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл гарсан тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэж, яаралтай засварлах арга хэмжээ авах;

5.1.8.дулаан дамжуулах төв болон зангилааг эмх цэгцтэй, цэвэр, байнгын гэрэлтүүлэгтэй байлгаж, агуулах, орон байрны зориулалтаар ашиглахгүй байх;

5.1.9.дулааны эрчим хүчийг хэмнэх, алдагдлыг хэвийн хэмжээнд байлгах, хувирсан усны буцалтыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, сүлжээний буцах усны халууныг бууруулах (эх үүсвэр нь дулаан цахилгааны төв байгаа тохиолдолд)-д чиглэсэн техник, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээг төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлэх;

5.1.10.дулааны эрчим хүч хэрэглэсэн тооцоог гэрээнд заасан хугацаанд хангагчтай хийж байх;

5.1.11.хяналтын болон хангагч байгууллагын шалгалтаар илэрсэн техник ашиглалт, аюулгүй ажиллагааны зөрчлийг арилгах, шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх;

5.1.12.ажил үүргээ гүйцэтгэж байгаа эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн төлөөлөгчийг өөрийн эзэмшлийн газарт саадгүй нэвтрүүлж, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээгээ шалгуулах;

5.1.13.өөрийн эзэмшлийн газарт байрласан дамжуулагч, түгээгч болон бусад хэрэглэгчийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж,



шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, засвар үйлчилгээ хийх боломж олгох;

5.1.14.хангагчтай тооцоо хийдэг тоолуурын бүрэн байдлыг хариуцаж, гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэх;

5.1.15.гэрээнд заасан дулааны эрчим хүчийг хугацаандаа авахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа хангагчид 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх;

5.1.16.Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм болон холбогдох бусад дүрэм, журмыг мөрдөж ажиллах;

5.1.17.эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн эрх бүхий ажилтны хийсэн битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;

5.1.18.нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан дулаан дамжуулах төв, дамжуулах, түгээх шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх;

5.1.19.шинээр барилга байгууламж холбуулж байгаа иргэн, хуулийн этгээд нь бусдын өмчлөлийн дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж, шугам сүлжээг өргөтгөн шинэчилсэн, анхдагч хаалт суурилуулсан, холболтын схемийг өөрчилсөн тохиолдолд холбогдон гарах зардлыг хариуцах;

5.1.20.дулаан дамжуулах 200 мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугам, түүний анхдагч таслах хаалт нь эрчим хүчний дамжуулах шугам тоноглол тул түүнийг төрийн өмчлөлд шилжүүлэх;

5.1.21.Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалтыг тус тус мөрдөж өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах, өөрийн шугамаас хэрэглэгч холбох үйл ажиллагаанаас ашиг олох зорилгоор бизнес үйл ажиллагаа явуулахгүй байх;

5.1.22.хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 32.2, 32.3-т заасан болон энэ дүрмийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад үндэслэлээр дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохирлоо төлүүлэх эрхтэй.



Зургаа. Хангагчийн эрх, үүрэг

6.1. Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлэх хүрээнд дараах эрх үүрэгтэй байна. Үүнд:

6.1.1. Эрчим хүчний тухай хууль, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн заалтыг хэрэгжүүлж, хэрэглэгчийг гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хангах;

6.1.2. дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ээлжит их болон урсгал засвар, туршилт тохируулгыг хугацаанд нь чанартай хийж, халаалтын бэлтгэлийг хангах, тоног төхөөрөмж, шугам сүлжээг засварт оруулахтай холбогдон дулааны эрчим хүчийг түр таслахаар бол энэ тухай хэрэглэгчид хуульд заасан хугацаанд урьдчилан мэдэгдэх;

6.1.3. дулаан хангамжийн системийн (эх үүсвэр, шугам сүлжээ, хэрэглэгчийн хэрэглээг оруулж) өвөл, зуны ажиллагааны горим тооцоог хийж, батлуулан хэрэгжүүлэх;

6.1.4. хэрэглэгчийн дулааны төв болон зангилааны зарцуулалтыг тохируулах хэрэгсэл (сопло, шайба)-ийг тооцож, бэлтгэн, хэрэглэгчээр тавиулж битүүмжлэх;

6.1.5. хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварын байдал, аюулгүй ажиллагааны шаардлага, халаалт, хэрэгцээний халуун ус хангамжийн чанар, уур ус, хувирсан усны алдагдал зэрэгт өөрийн төлөөлөгчөөр хяналт тавиулан, илэрсэн зөрчлийг арилгуулах;

6.1.6. сүлжээний буцах усны халууныг тогтвортой бууруулж, хувирсан ус буцаалтыг нэмэгдүүлэн эх үүсвэрийн ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх;

6.1.7. шинэ хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралтад хяналт тавьж, техникийн нөхцөл, зураг төслийн дагуу хийлгэж, ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд төлөөлөгчөө оролцуулах;

6.1.8. хэрэглэгчийн захиалгаар дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд засвар, үйлчилгээ хийх үед нь түүний дулааныг таслах;

6.1.9. дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд ээлжит бус засвар хийх, шинэ хэрэглэгч холбох тохиолдолд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэж хугацааг тохирсноор дулааныг түр таслах;

6.1.10.дулааны эх үүсвэр болон дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гарсан ноцтой гэмтэл саатлыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд дулаан хангамжийг шууд зогсоох эрхтэй бөгөөд зогсоосон шалтгаанаа хэрэглэгчид нэн даруй мэдэгдэх;

6.1.11.Эрчим хүчний тухай хуулийн 32.2-т заасан хангагчийн эрх бүхий ажилтныг томилох;

6.1.12.гадна агаарын температур буурч, өвлийн ачаалалд шилжихтэй холбогдуулан хот, суурин газрын дулаан хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор тухайн оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд (аваар, саатлаас бусад) дулааны шугамаас огтолгоо авч, сүлжээнд хэрэглэгч шинээр холбохгүй, дулаан хангамжийн ажиллагааг зогсоохгүй байх;

6.1.13.үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч нь дулааны тасалдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, шугам тоноглолын засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгэж, машин механизм, хүн хүч, тоног төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах;

6.1.14.улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар нийтийн эрх ашгийн үүднээс хийгдэж байгаа инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлыг саатуулсан иргэн, хуулийн этгээдийг эрчим хүчээр хангахгүй, хязгаарлах, хохирлыг төлүүлэх, техникийн нөхцөл олгохгүй байх;

6.1.15.гэрээлсэн эрчим хүчний үнэ, тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.

Долоо. Төлбөр тооцооны хэмжих хэрэгслийн ашиглалт

7.1.Дамжуулагч, түгээгч болон хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж шугам сүлжээг Эрчим хүчний тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль тогтоомжийн шаардлагыг хангасан төлбөр тооцооны болон хянах хэмжих хэрэгсэл тохируулах автоматаар тоноглосон байна.

7.2.Иргэн, хуулийн этгээдийн ажлын байр, орон сууцны халаалт болон хэрэгцээний халуун усны төхөөрөмж дээр Хэмжил зүйн тухай хуулийн шаардлагыг хангасан төлбөр тооцооны болон хянах хэмжих хэрэгслийг суурилуулна.



7.3.Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгч нь хэрэглэгчийн эзэмшлийн тоног төхөөрөмжид дулааны тоолуур, хянах хэрэгсэл, тохируулах автомат тавих, тэдгээрийг ашиглах, засварлах, баталгаажуулах, бүрэн бүтэн байлгах асуудлыг хариуцна.

7.4.Хэрэглэгчийн тоног төхөөрөмж, шугам сүлжээнд тавьсан хянах, хэмжих хэрэгсэл, автомат тохируулагч болон төлбөр тооцооны тоолуур нь хэвийн ажиллагаатай байгаа эсэхэд хангагч хяналт тавина.

7.5.Уур, усаар түгээсэн дулааны төлбөр тооцоог хангагч болон хэрэглэгчийн шугамын зааг дээрээс эхлэн тооцно. Төлбөр тооцооны тоолуурыг шугамын заагаас зайтай байрлуулсан бол хэрэглэгчийн дулааны эрчим хүчний тооцоонд шугамын заагаас тоолуур хүртэлх шугамын алдагдлыг хангагч болон хэрэглэгч харилцан тохиролцож оруулна.

7.6.Түгээгч нь төлбөр тооцооны тоолуурыг зөөж байрлуулах шаардлага гарсан тохиолдолд хэрэглэгч, хангагчийн төлөөлөгчийг байлцуулж, гүйцэтгэнэ.

Найм. Төлбөр тооцооны журам

8.1.Хангагч, хэрэглэгчийн хооронд хийх төлбөр тооцоог тоолуурын заалт (бусад тохиолдолд гэрээ)-ыг үндэслэн мөрдөж байгаа үнийн дагуу хийнэ.

8.2.Хэрэглэгчийн тоолуур гэмтэлтэй тохиолдолд төлбөр тооцоог зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн (задгайгаар) хийнэ.

8.3.Хэрэглэгч нь хувирсан усыг гэрээнд заасан хэмжээнээс илүү хэмжээгээр буцаасан тохиолдолд түүнд урамшуулал үзүүлэх бөгөөд дутуу буцаавал хангагчид торгууль төлнө. Урамшуулал болон торгуулийн хэмжээг гэрээнд тусгана.

8.4.Хэрэглэгчээс буцаасан хувирсан усны чанар нь гэрээнд заасан чанарын үзүүлэлтийг хангаагүй бол буцаагаагүйд тооцно. Үүнтэй холбогдон гарах төлбөрийн хэмжээг гэрээгээр зохицуулна.

8.5.Хэрэглэгч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол сард хэрэглэх дулааны эрчим хүчний үнийн 50 хувьтай тэнцэх төлбөрийг тухайн сарын 10-ны дотор урьдчилан төлж болно.

8.6.Хэрэглэгч нь сүлжээний буцах усны халууныг батлагдсан графикаас 4 хэмээс дээш хэмжээгээр өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн хэмд ногдох ашиглахгүй буцаасан дулааны үнийг тооцож төлнө.

8.7. Дулааны эрчим хүчний тооцоог хэрэглэгч буруу гэж үзвэл энэ тухай хангагчид албан ёсоор мэдэгдэнэ. Хангагч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор маргааныг шийдвэрлэнэ.

8.8. Хэрэглэгч нь хангагчийн энэ дүрмийн 8.7-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Эрчим хүчний тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

8.9. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан тооцооны үнийн зөрүүг хангагч, хэрэглэгч хоёр тал хамтран үйлдсэн актын үндсэн дээр дараа сарын тооцоонд тусгана.

8.10. Хэрэглэгчийг дулаанаар хязгаарласан буюу тасалсан эрчим хүчний хэмжээг тодорхойлохдоо хэрэглэгч болон үйлдвэрлэгчийн тооцооны тоолуурын заалт, ээлжийн диспетчерийн албан ёсны тэмдэглэлийг үндэслэнэ.

8.11. Хэрэглэгч тухайн байрнаасаа түр буюу бүр мөсөн нүүсэн, байраа бусдад шилжүүлсэн бол энэ тухай хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэж, хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөр тооцоог хийж, өр авлагыг барагдуулах үүрэгтэй.

Ес. Дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх

9.1. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтан нь Эрчим хүчний тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан болон дараах тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ. Үүнд:

9.1.1. дулааны эрчим хүчийг гэрээнд заагаагүй зориулалтаар ашигласан, ус, дулааны алдагдлыг нормд заасан хэмжээнээс хэтрүүлсэн;

9.1.2. эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл бүрдүүлээгүй буюу техникийн нөхцөлийн шаардлагыг зөрчсөн, зөвшөөрөлгүй барилга байгууламж холбож дулаан авсан;

9.1.3. хангагчаас тооцоолж битүүмжлэн тавьсан, тохируулах хэрэгсэл (сопло, шайба)-ийг дур мэдэн өөрчлөх буюу авах замаар бусдын дулаан хангамжийг доголдуулсан;

9.1.4. тооцооны хэмжүүрт оруулахгүй зүй бусаар холболт хийж, дулаан (уур, ус) авч ашигласан;

9.1.5. хэрэглэсэн дулааны болон буцаагаагүй хувирсан усны төлбөрийг дараа сарын 10-ны дотор төлөөгүй.



9.2.Эрчим хүчний хяналтын улсын байцаагч болон хангагчийн эрх бүхий ажилтан хэрэглэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх тухай шийдвэртээ шалтгааныг тодорхой зааж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тоолуур болон шаардлагатай бусад хэрэгслийг битүүмжилнэ.

9.3.Эрчим хүчний хангамж, хэрэглээг нь түдгэлзүүлсэн тухай шийдвэрт заасан шалтгааныг хэрэглэгч арилгасан тухайгаа хангагчид мэдэгдэж шалгуулахаас өмнө уг тоног төхөөрөмж, шугам сүлжээг ашиглахгүй.

Арав. Хохирлыг тооцох, нөхөн төлөх

10.1.Хангагч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрчим хүчийг тасалдуулсан тохиолдолд хэрэглэгч нь энэ талаар хангагчид тухай бүр шуурхай мэдэгдэнэ.

10.2.Дулааны эрчим хүч тасалдсанаас болон чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс үүссэн хохирлыг тогтоохдоо хангагч, хэрэглэгчийн хамтран үйлдсэн актыг үндэс болгоно.

10.3.Энэ дүрмийн 10.2-т заасан актад дулааны эрчим хүч тасалдсан, хэлбэлзсэн он, сар, өдөр, үргэлжилсэн хугацаа, шалтгаан, үйлдвэрлэл, үйлчилгээнд учруулсан шууд бус хохирлын хэмжээ болон хангагч, хэрэглэгчийн төлөөлөгчийн нэр, албан тушаалыг тодорхой бичиж гарын үсэг зурж, хангагч, хэрэглэгчийн холбогдох албан тушаалтан баталгаажуулсан байна.

10.4.Актыг талууд 5 хоногийн дотор хамтран тогтоож, хохирлыг 2 сарын дотор буруутай тал хариуцан төлнө.

10.5.Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээг гуравдагч этгээд гэмтээж хохирол учруулсан тохиолдолд (шинээр барилга барих, газар шорооны ажил хийх үед) хэрэглэгч, хангагч хамтран акт тогтоож буруутай этгээдээр хохирлыг арилгуулах, тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай болгох асуудлыг хамтран шийдвэрлэнэ.

10.6.Чанарыг бууруулан түгээсэн дулааны эрчим хүчний төлбөр тооцоог тухайн хэрэглэгчийн хянах хэмжих хэрэгслийн заалтаар тогтоож хийнэ.

10.7.Дулааны эрчим хүчний тасалдлаас учирсан шууд бус хохирлыг арилгах талаар гэрээнд тодорхой тусгасан байна.

10.8.Эрчим хүч ашиглах дүрэм, горим, гэрээг зөрчиж хууль бусаар хэрэглэсэн дулааны эрчим хүчний үнийг хэрэглэгч нөхөн төлнө.

10.9.Дараах тохиолдолд дулааны эрчим хүч тасалснаас хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй. Үүнд:



10.9.1.байгалийн гэнэтийн аюул (усны үер, гал түймэр, газар хөдлөлт гэх мэт) тохиолдсон;

10.9.2.хэрэглэгч болон бусад байгууллага, иргэний буруутай үйл ажиллагаанаас үүссэн;

10.9.3.дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлсэн.

Арван нэг. Хяналт, хариуцлага

11.1.Энэ дүрмийн биелэлтэд эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан, ажилтан, мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч хяналт тавина.

11.2.Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрчим хүчний хангамж, мөрдөж байгаа үнэ тарифын үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

11.3.Хангагч, хэрэглэгч талууд хоорондоо зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй дулааны эрчим хүчний хангамж, хэрэглээтэй холбогдсон маргааныг Эрчим хүчний тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

11.4.Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2020 оны
97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ШУГАМ СҮЛЖЭЭГ ХАМГААЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас тогтоох, түүний хүрээнд ажил, үйлчилгээ явуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас

2.1.Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг саадгүй явуулах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын зурвас тогтооно.



2.2. Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг дор дурдсан нөхцөл, хэмжээг баримтлан тогтооно:

№	Шугам сүлжээний ангилал	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой, цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш			Шугамын захын утаснаас хоёр тийш
1.	Цахилгаан дамжуулах шугам: а/ 1кВ хүртэл	-	1-1,5 м	-	-	-	-	-
	б/1-20 хүртэл кВ	10 м	2 м	10 м	-	-	-	2 м
	в/35 кВ	15 м	4 м	15 м	-	-	-	3 м
	г/110 кВ	20 м	5 м	20 м	-	-	-	3 м
	д/220 кВ	25 м	6 м	25 м	-	-	-	4 м
	е/330-500 кВ	30 м	10 м	30 м	-	-	-	5 м
2.	Кабель шугам	-	-	-	-	1 м	100 м	-
3.	Дулааны шугам: а/500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м	-	-
	б/500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м	-	-
4.	Үнсэн сан			30 м				

2.3. Дэд станц, хуваарилах байгууламж, ой, тариа, ногооны талбайд байрших тохиолдолд түүний эргэн тойрон 25 м газарт ой байлгах, үр тариа, төмс, хүнсний ногоо тариалахыг хориглоно.

2.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүчний шугам сүлжээ эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, эрчим хүчний шугам сүлжээний зурвасын зураглалыг үндэслэн Эрчим хүчний тухай хуулийн 33.2-т заасны дагуу хамгаалалтын зурвасыг тогтооно.

2.5.Усны үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гэнэтийн аюул болон үйлдвэрлэлийн ослын улмаас эрчим хүчний шугам сүлжээнд гэмтэл гарсан тохиолдолд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тэдгээрийг хамгаалах болон гэмтлийг арилгах талаар шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулна.

2.6.Хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, орон сууц, гэр, хашаа барих, шугам сүлжээ эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2.7.Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт эрчим хүчний шугам сүлжээ барьж байгуулах зайлшгүй шаардлага гарвал түүний улмаас үүдэн гарах бүхий л зардлыг шугам сүлжээг бариулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

Гурав. Хамгаалалтын зурваст ажил, үйлчилгээ явуулах

3.1.Хамгаалалтын зурваст инженерийн шугам сүлжээ барьж байгуулах, авто замын гарц гаргах, газар шорооны ажил гүйцэтгэхдээ эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг авсан байна.

3.2.Хамгаалалтын зурваст эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.3.Эрчим хүчний шугам сүлжээг шилжүүлэх, түүнд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлыг хүсэлт тавьсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцаж, шугам сүлжээг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг авч түүний хяналтын дор гүйцэтгэнэ.

3.4.Эзэмшигч байгууллага нь хамгаалалтын зурвас дотор байрласан газар доорх инженерийн шугам сүлжээний байршлын зураглалыг эрчим хүчний хангагч байгууллагад өгсөн байвал зохино.

3.5.Хамгаалалтын зурвас дотор газар шорооны ажил гүйцэтгэсний дараа хамгаалалтын зурвасын талбайг хэвийн байдалд нь оруулан сэргээнэ.

3.6.Хамгаалалтын зурвас дотор тарьсан мод бут нь шугам сүлжээнд хор хохирол, гэмтэл учруулах буюу үзлэг үйлчилгээ хийхэд саад болох тохиолдолд мод, бут эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй.



Дөрөв. Эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигчийн үүрэг

4.1. Эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:

4.1.1. хамгаалалтын зурваст дэглэм сахиулах, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлыг гүйцэтгэх;

4.1.2. автомашины замын дээгүүр дулаан дамжуулах шугам гарсан нөхцөлд тухайн хэсэгт тээврийн хэрэгслийн (ачаатай болон ачаагүй) өндөр, өргөний хэмжээг заасан тэмдэг санамжийг замын ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран тавих;

4.1.3. ой дундуур цахилгаан дамжуулах шугам гарсан тохиолдолд хамгаалалтын зурвас доторх унанги мод, мөчир, гишүүг цэвэрлэж байх;

4.1.4. шугам сүлжээний хамгаалалтын зурвасын байршлын зураглалыг хийх, хамгаалалтын зурвасыг тогтоолгох тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаар гаргуулах;

4.1.5. дулааны шугамыг хөрсний эвдрэлээс үүсч болох гэмтэл, бусад нөлөөлөл, бохирдлоос хамгаалах;

4.1.6. хамгаалалтын зурвас зөрчсөн хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр хангахгүй байх талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нар хамтран хяналт тавьж, хэрэгжүүлэх.

Тав. Дүрмийн биелэлтэд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага

5.1. Энэхүү дүрмийн биелэлтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эрчим хүчний зохицуулагч болон хяналтын улсын байцаагч, эрчим хүчний шугам сүлжээг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага өөр өөрийн чиглэлээр хяналт тавина.

5.2. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Эрчим хүчний тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ
ГЭМТ ЭТГЭЭД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛС
БОЛОН
МОНГОЛ УЛС
ХООРОНДЫН ГЭРЭЭ

Монгол Улс болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс (цаашид бие даан “тал”, хамтдаа “талууд” гэх);

хоёр орны найрамдалт харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн;

гэмт хэргийг таслан зогсооход хоёр орны хооронд илүү үр дүнтэй хамтын ажиллагаа шаардлагатайг хүлээн зөвшөөрч;

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх үүрэг

Талууд энэхүү гэрээний заалтын дагуу өөрсдийн нутаг дэвсгэр дээр байгаа болон нөгөө талаас шүүн таслах ажиллагаа явуулах, эсхүл шилжүүлбэл зохих гэмт хэрэгт ял оногдуулах зорилгоор шилжүүлэхийг хүссэн этгээдийг харилцан шилжүүлэн өгч байхаар тохиролцов.

2 ДУГААР ЗҮЙЛ

Шилжүүлбэл зохих гэмт хэрэг

1. Энэхүү гэрээний зорилгоор гэмт этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэдэг нь талуудын хууль тогтоомжийн дагуу нэг (1) жилээс доошгүй хугацаагаар хорих ял, эсхүл түүнээс хүнд ял оногдуулахаар заасан гэмт хэргийг хэлнэ.
2. Гэмт этгээдийг шилжүүлэх тухай хүсэлт нь шүүхээс хорих ял оногдуулахаар аливаа этгээдийг шилжүүлэхтэй холбогдолтой бөгөөд оногдуулах ялын үлдсэн хугацаа нь зургаан (6) сараас доошгүй бол гэмт этгээдийг шилжүүлэн өгнө.
3. Энэ зүйлийн зорилгоор, гэмт хэргийг талуудын хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг тогтооходоо:



- a) талуудын хууль тогтоомжид гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдлийг хуулийн нэг зүйлээр зүйлчлэх, эсхүл ижил нэр томъёогоор тодорхойлж буй эсэхийг үл харгалзана;
 - b) шилжүүлэхийг хүссэн этгээдийн үйлдсэн үйлдлийг нийтэд нь харгалзан үзэж, гэмт хэргийг бүрэлдүүлж буй үйлдэл, эс үйлдлийг талуудын хууль тогтоомжид өөр өөрөөр заасан эсэхийг үл харгалзана.
4. Шилжүүлэхийг хүссэн этгээд нь татвар, гаалийн хураамж, гадаад валютын солилцооны хяналт болон бусад орлоготой холбоотой хуулийг зөрчсөн бол хүсэлт хүлээн авагч талын хуулиар ижил төрлийн татвар буюу хураамж оногдуулдаггүй, эсхүл хүсэлт гаргагч талын хуульд заасантай ижил төрлийн татвар, хураамж, гааль буюу валютын асуудлаар зохицуулалтгүй гэсэн үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзахгүй.
5. Хэрэв гэмт хэрэг хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрээс гадна үйлдэгдсэн боловч хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжид өөрийн нутаг дэвсгэрээс гадна ижил төстэй нөхцөлд үйлдэгдсэн гэмт хэрэгт ял оногдуулахаар заасан бол гэмт этгээдийг шилжүүлэн өгнө. Хэрэв хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжид ийнхүү заагаагүй бол хүсэлт хүлээн авагч тал гэмт этгээдийг шилжүүлэн өгөх эсэхийг өөрөө шийдвэрлэнэ.
6. Энэхүү гэрээний дагуу дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлж болно. Үүнд:
- a) гэмт үйлдэл, эс үйлдэл гарах үед тэдгээр нь хүсэлт гаргагч талын хуулиар гэмт хэрэгт тооцогддог байх;
 - b) гэмт үйлдэл, эс үйлдэл нь хэрэв гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтийг гаргах үед хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэр дээр гарсан бол хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар гэмт хэрэгт тооцогддог байх.

3 ДУГААР ЗҮЙЛ

Шилжүүлэн өгөхөөс татгалзах

1. Дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэхээс татгалзана. Үүнд:
 - a) гэмт этгээдийг шилжүүлэн авах тухай хүсэлт нь тухайн этгээдийг арьс өнгө, үндэс угсаа, хүйс, хэл, шашин шүтлэг,

иргэншил, улс төрийн үзэл бодол болон бусад байдлаар нь ял шийтгэх гэж байгаа, эсхүл шүүн таслах ажиллагааны үеэр дээрх шалтгаанаар хохироох бодитой үндэслэлтэй хэмээн хүсэлт хүлээн авагч тал үзсэн бол;

- b) шилжүүлэхийг хүссэн этгээдийг шилжүүлэн авахаар хүсэлт болгосон тухайн гэмт хэрэгт холбогдуулан хүсэлт хүлээн авагч талын, эсхүл гуравдагч улсын хууль тогтоомжийн дагуу цагаатгасан, өршөөл үзүүлсэн болон шийтгэл оногдуулсан бол;
- c) хэлэлцэн тохирогч талуудын хууль тогтоомжийн дагуу шилжүүлбэл зохих гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны улмаас шилжүүлэхийг хүссэн этгээдийг шүүн таслах болон яллахгүй болсон;
- d) гэмт этгээдийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан талын хуулиар уг этгээд цаазаар авах ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн, харин хүсэлт хүлээн авсан талын хуулиар уг гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахааргүй бол хүсэлт гаргасан талаас хүсэлт хүлээн авсан талд цаазаар авах ял оногдуулахгүй гэсэн хангалттай баталгаа гаргаж өгөхгүй бол;
- e) хүсэлт гаргагч тал шилжүүлэхийг хүссэн этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний бие махбодыг доройтуулах болон хэрцгий хандах бодитой үндэслэлтэй хэмээн хүсэлт хүлээн авагч тал үзсэн бол.

2. Дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэхээс татгалзаж болно. Үүнд:

- a) Хүсэлт хүлээн авагч талын хувьд шилжүүлэхийг хүссэн гэмт хэрэг нь улс төрийн шинжтэй гэмт хэрэгт хамаарахаар бол. Төрийн тэргүүн болон түүний гэр бүлийн гишүүдийн амь насанд халдсан, халдахаар завдсан үйлдэл эсхүл талуудын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээрээр эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохоор заасан бол улс төрийн гэмт хэрэгт хамааруулахгүй;
- b) хүсэлт хүлээн авагч талын хувьд гэмт этгээдийг шилжүүлэхийг хүссэн гэмт хэрэг нь цэргийн хуулиар шийтгэгдэх гэмт хэрэг бөгөөд хүсэлт хүлээн авагч талын эрүүгийн хуульд хамааралгүй бол;



- c) хүсэлт хүлээн авагч талын хуулиар шилжүүлэхийг хүссэн гэмт хэрэг нь өөрийн нутаг дэвсгэр дээр бүхэлдээ, эсхүл, хэсэгчлэн үйлдэгдсэн хэмээн үзсэн бол;
 - d) хүсэлт хүлээн авагч талд шилжүүлбэл зохих гэмт хэрэгт холбогдуулан шилжүүлэхийг хүссэн этгээдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа бол;
 - e) шилжүүлэхийг хүссэн этгээд ял шийтгүүлсэн эсхүл, хүсэлт гаргагч талд тусгай, түр зуурын болон хөндлөнгийн шүүхээр шүүн таслах ажиллагаа явуулах болон ял шийтгүүлэх гэж байгаа бол;
 - f) хүсэлт хүлээн авагч тал тухайн гэмт хэргийн хүнд, хөнгөн болон хүсэлт гаргагч талын ашиг сонирхлыг харгалзан үзэхийн хамтаар, шилжүүлэхийг хүссэн этгээдийн хувийн нөхцөл байдлаас шалтгаалан ийнхүү шилжүүлэн өгөх нь хүмүүнлэгийн үүднээс нийцэхгүй байна хэмээн үзэж байгаа бол.
3. Хүсэлт хүлээн авагч тал шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагч талд татгалзаж буй үндэслэлээ даруй бичгээр мэдэгдэнэ.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Түр шилжүүлэх болон шилжүүлэн өгөхийг хойшлуулах

1. Хүсэлт хүлээн авагч талд шилжүүлэхийг хүссэн этгээд шилжүүлбэл зохих гэмт хэргээс өөр гэмт хэрэгт шалгагдаж байгаа эсхүл, ял эдэлж байгаа бол хүсэлт хүлээн авагч тал хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах хүртэл эсхүл оногдуулсан ялыг эдэлж дуусах хүртэл тухайн этгээдийг шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно. Хүсэлт хүлээн авагч тал хойшлуулж байгаа тухайгаа хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ.
2. Хүсэлт хүлээн авагч талд шалгагдаж байгаа этгээдийг шилжүүлэн авах тухай хүсэлт гаргавал хүсэлт хүлээн авагч тал тухайн этгээдийн гэм буруутай нь тогтоогдож хорих ялаар шийтгэгдсэн хэдий ч шилжүүлэн авах хүсэлтийн хүрээнд гэмт этгээдийг шилжүүлэх ажиллагааны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зорилгоор хүсэлт гаргагч талд түр шилжүүлж болно.
3. Талууд тогтоосон нөхцөлийн дагуу харилцан зөвшилцөж түр хугацаагаар шилжүүлэн өгсөн этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж дууссаны дараа хүсэлт гаргагч тал түүнийг түр саатуулан хорино.

5 ДУГААР ЗҮЙЛ

Иргэнийг шилжүүлэх

1. Аль ч тал өөрийн улсын иргэнийг шилжүүлэн өгөхгүй.
2. Хүсэлт хүлээн авагч тал энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өөрийн улсын иргэнийг шилжүүлэн өгөхөөс татгалзвал хүсэлт хүлээн авагч талын шүүх уг гэмт хэргийг харьяалан хянан шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл хүсэлт хүлээн авагч тал шилжүүлэхийг хүссэн этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэргүүдийн бүгдэд нь эсхүл аль нэгэнд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх журам, шаардагдах бичиг баримт

1. Гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтийг бичгээр үйлдэж, энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заасан эрх бүхий төв байгууллага хооронд шууд дамжуулна.
2. Гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтэд дараах зүйлийг хавсаргана. Үүнд:
 - a) гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтийн огноо, газар;
 - b) хүсэлт гаргагч байгууллагын нэр, хаяг;
 - c) шилжүүлэхийг хүссэн этгээдийн үнэн зөв мэдээлэл, тухайн этгээдийн хувийн шинж болон иргэний харьяаллыг тогтооход хэрэг болох бусад мэдээлэл, боломжтой тохиолдолд зураг, хурууны хээ, тухайн этгээдийн байршил;
 - d) гэмт хэргийн бүрэлдэхүүн болон шилжүүлбэл зохих гэмт хэргийн талаарх тайлбар, үүнд гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа болон газар түүнчлэн хуулийн дагуу оногдуулбал зохих шийтгэлийн мэдээлэл;
 - e) тухайн гэмт хэрэг, түүнд оногдуулах ял шийтгэл болон уг хэргийн хөөн хэлэлцэх хугацаа эсхүл тухайн хэрэгт ялыг гүйцэтгэх ажиллагаа зэргийг заасан хуулийн холбогдох заалтын эшлэл.
3. Яллагдагч этгээдийг шилжүүлэх хүсэлтэд хүсэлт гаргагч талын шүүгч, эсхүл бусад эрх бүхий байгууллагын баривчлах тогтоолын хуулбарыг хавсаргана.



4. Гэм буруутай нь тогтоогдсон этгээдийг шилжүүлэх хүсэлтэд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагаас гадна хүсэлт гаргагч талын шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын хуулбарыг хавсаргана. Хэрэв тухайн этгээд гэм буруутай нь тогтоогдож ял шийтгэгдсэн бол гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтэд эдэлсэн ялын хугацааны талаарх мэдээллийг хавсаргана. Хэрэв тухайн этгээд гэм буруутай нь тогтоогдсон боловч ял шийтгүүлээгүй бол гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтэд түүний үр дагаврын талаарх мэдээллийг хавсаргана.
5. Энэхүү гэрээний дагуу хүсэлт болон дагалдах баримт бичиг, бусад мэдээлэл нь хүсэлт гаргагч талын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тэмдэгтэй байх бөгөөд хэрэв дээрх албан бичиг хүсэлт хүлээн авагч талын албан ёсны хэлээр үйлдэгдсэн бол англи хэлээрх орчуулгыг хавсаргана.

7 ДУГААР ЗҮЙЛ

Нэмэлт мэдээлэл

1. Хэрэв хүсэлт хүлээн авагч тал шилжүүлэх хүсэлт болон бусад мэдээлэл нь энэхүү гэрээний дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөд хангалттай бус хэмээн үзвэл тухайн тал тодорхой хугацаа зааж, уг хугацааны дотор нэмэлт мэдээлэл авахыг хүсч болно.
2. Шилжүүлэхийг хүссэн этгээдийг баривчилсан боловч нэмэлт мэдээлэл нь энэхүү гэрээний хүрээнд хангалттай бус, мөн уг мэдээллийг тогтоосон хугацаанд хүлээн аваагүй бол тухайн этгээдийг суллаж болно. Ийнхүү суллах нь хүсэлт гаргагч тал дахин хүсэлт гаргахад саад болохгүй.
3. Хүсэлт хүлээн авагч тал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу аливаа этгээдийг суллахаас өмнө энэ тухайгаа хүсэлт гаргагч талд аль болох түргэн хугацаанд мэдэгдэнэ.

8 ДУГААР ЗҮЙЛ

Эрх бүхий төв байгууллага

1. Монгол Улсын эрх бүхий төв байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам байна.
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын эрх бүхий төв байгууллага нь Нийгмийн аюулгүй байдлын яам байна.
2. Талуудын эрх бүхий төв байгууллага гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтийг энэхүү гэрээ болон талуудын хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.



3. Талуудын эрх бүхий төв байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа дипломат шугамаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Урьдчилан баривчлах

1. Яаралтай тохиолдолд аль ч тал гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтийг гаргахын өмнө эрэн сурвалжлагдаж буй этгээдийг урьдчилан баривчлуулах хүсэлт гаргаж болно.
2. Урьдчилан баривчлуулах хүсэлтийг бичгээр үйлдэх бөгөөд энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заасан журмын дагуу шууд дамжуулах, эсхүл Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага буюу Интерпол болон талуудын харилцан тохиролцсон өөр шугамаар дамжуулж болно.
3. Урьдчилан баривчлах хүсэлтэд энэхүү гэрээний 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг мөн зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт заасан баримт бичгийг шилжүүлэхийг хүссэн этгээдийг урьдчилан баривчлах тухай албан ёсны мэдэгдлийн хамт хавсаргана.
4. Хүсэлт хүлээн авагч тал урьдчилан баривчлах тухай хүсэлтийг хүлээж авсан даруй хүсэлтийн дагуу авсан арга хэмжээний талаар гаргасан талд даруй мэдэгдэнэ.
5. Хүсэлт хүлээн авагч тал баривчлагдсан этгээдийг цагдан хорьсон өдрөөс хойш жар (60) хоногийн дотор 6 дугаар зүйлд заасан шилжүүлэн өгөх хүсэлт болон баримт бичгийг хүлээн аваагүй бол баривчлагдсан этгээдийг суллана. Хэрэв хүсэлтийг дараа нь хүлээн авсан бол эрэн сурвалжилж байгаа этгээдийг шилжүүлэхэд саад болохгүй.

10 ДУГААР ЗҮЙЛ

Зөвшөөрлийн дагуу шилжүүлэх

Шилжүүлэхийг хүссэн этгээд нь хүсэлт гаргагч талын шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан шилжүүлэхийг хүссэн хүсэлтийг зөвшөөрч буйгаа бичгээр мэдэгдсэн бол хүсэлт гаргагч тал шилжүүлэн авах ажиллагааг түргэвчлэх талаар бүхий л арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авна.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Нэгэн зэрэг гаргасан хэд хэдэн хүсэлт

1. Хэрэв аль нэг этгээдийг нэг төрлийн, эсхүл өөр өөр төрлийн гэмт хэргийн улмаас шилжүүлэн өгөхийг хүсэлт гаргагч тал болон нэг



буюу түүнээс дээш тооны улс нэгэн зэрэг хүсэлт гаргасан бол хүсэлт хүлээн авагч тал эдгээр улсаас аль улсад тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай шийдвэр гаргаж, өөрийн шийдвэрийн талаар эдгээр улсад мэдэгдэнэ.

2. Тухайн этгээдийг аль улсад шилжүүлэн өгөх тухай шийдвэр гаргахдаа холбогдох бүх хүчин зүйлийг харгалзан үзэх бөгөөд ингэхдээ дараах зүйлийг онцгойлон авч үзнэ:
 - a) хүсэлтийг аливаа гэрээний дагуу гаргасан эсэх;
 - b) шилжүүлэхийг хүссэн этгээдийн иргэний харьяалал;
 - c) шилжүүлэх хүсэлт нь өөр өөр гэмт хэрэгт холбогдолтой бол, тэдгээр гэмт хэргийн хүнд, хөнгөн байдлын хамаарал;
 - d) гэмт хэрэг тус бүрийн үйлдэгдсэн цаг хугацаа, газар;
 - e) хүсэлт гаргагч улсаас хүлээж авсан хүсэлтийн дараалал;
 - f) шилжүүлэхийг хүссэн этгээдийн оршин суугаа газар ;
 - g) хүсэлт гаргагч улсын ашиг сонирхол;
 - h) хохирогчийн иргэний харьяалал;
 - i) хүсэлт гаргагч улстай цаашид гэмт этгээд шилжүүлэн өгөх боломж бий эсэх.
3. Энэхүү зүйлд “улс” гэсэн нэр томъёог олон улсын эрх зүйд заасан тодорхойлолтоор ойлгох бөгөөд уг ойлголтод тухайн улсын бие даасан Засгийн газраас гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлт гаргах эрх зохих ёсоор олгогдсон аливаа улсын нутаг дэвсгэрийг хамааруулна.

12 ДУГААР ЗҮЙЛ

Гэмт этгээдийг гуравдагч улсад шилжүүлэх

Хүсэлт хүлээн авагч талаас хүсэлт гаргагч талд шилжүүлэн өгч байгаа этгээдийг шилжүүлэн өгөхдөө доор дурдсанаас бусад тохиолдолд хүсэлт гаргагч тал тухайн этгээдийг өмнө үйлдсэн гэмт хэрэгт холбогдуулан гуравдагч улсад шилжүүлэн өгч болохгүй. Үүнд :

1. Хүсэлт хүлээн авагч тал нь шилжүүлэн өгөх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн. Ийнхүү зөвшөөрөл хүссэн хүсэлтэд 6 дугаар зүйлд дурдсан баримт бичгийг хавсарган хүсэлт хүлээн авагч талд хүргүүлнэ;



2. Этгээд нь хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрээс гарч явахад чөлөөтэй байсан ба шилжүүлбэл зохих гэмт хэргийн хувьд чөлөөлөх эцсийн шийдвэр гарснаас хойш дөчин тав (45) хоногийн дотор гараагүй бол;
3. Этгээд нь хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрээс гарсны дараа сайн дураар буцаж ирсэн бол.

13 ДУГААР ЗҮЙЛ

Гэмт этгээдийг хүлээлгэн өгөх

1. Хүсэлт хүлээн авагч тал гэмт этгээдийг шилжүүлэх талаар шийдвэр гаргасан даруйд хүсэлт гаргагч талд тухайн шийдвэрийн талаар энэхүү гэрээний 8 дугаар зүйлд заасан эрх бүхий төв байгууллагаар дамжуулан мэдэгдэнэ.
2. Талууд хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт байрлах хүсэлт гаргагч талын холбогдох эрх бүхий байгууллагад хандаж тухайн этгээдийг шилжүүлэн өгөх огноо болон газрыг харилцан тохиролцон шийдвэрлэнэ.
3. Хүсэлт гаргагч тал тухайн этгээдийг хүсэлт хүлээн авагч талын заасан хугацааны дотор хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрээс шилжүүлэн авах бөгөөд энэ хугацаанд тухайн этгээдийг шилжүүлэн аваагүй бол хүсэлт хүлээн авагч тал уг этгээдийг суллаж, тухайн гэмт хэрэгт холбогдуулан шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.
4. Аль нэг тал өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас гэмт этгээдийг шилжүүлж өгөх эсхүл шилжүүлж аваагүй бол энэ тухай аль болох боломжит хугацаанд нөгөө талдаа мэдэгдэнэ. Хоёр тал гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, эсхүл шилжүүлэн авах шинэ огноог харилцан шийдвэрлэх бөгөөд үүнд энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг баримтална.
5. Энэхүү гэрээний дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгвөл хүсэлт гаргагч тал шилжүүлсэн гэмт этгээдийн хэргийг шүүхээр шийдвэрлүүлэх асуудлыг хариуцна.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Эд хөрөнгө хураан авах, хүлээлгэн өгөх

1. Хүсэлт хүлээн авагч тал өөрийн улсын хууль, тогтоомжийн хүрээнд болон гуравдагч талын эрх ашгийг бүрэн хүндэтгэх үндсэн дээр гэмт



этгээдийг шилжүүлэхээр болсон бол хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт илэрсэн гэмт хэрэгт холбогдолтой бүхий л эд хөрөнгийг нотлох баримт болгон ашиглах зорилгоор хүсэлт гаргагч талд хүлээлгэн өгнө.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан дээр дурдсан эд хөрөнгийг гэмт этгээд нас барсан буюу оргон зайлсан аль ч нөхцөлд хэрэв хүсэлт гаргагч тал хүсэлт гаргавал хүлээлгэн өгнө.
3. Хүсэлт хүлээн авагч тал хүсэлт гаргагч талаас тухайн эд хөрөнгийг хүсэлт хүлээн авагч талд боломжит хугацаанд буцаан хүргүүлэх хангалттай баталгааг хүсэлт гаргагч талаас гаргуулж эд хөрөнгийг шилжүүлэх болзол тавьж болно. Хэрэв хүсэлт хүлээн авагч талд тухайн эд хөрөнгө нотлох баримтын хэмжээнд шаардлагатай бол хүсэлт хүлээн авагч тал тэдгээрийг хүлээлгэн өгөхийг хойшлуулж болно.
4. Хүсэлт гаргагч тал шилжүүлсэн эд хөрөнгийг буцаахтай холбогдон гарах бүх зардлыг хариуцна.

15 ДУГААР ЗҮЙЛ

Онцгой журам

1. Энэхүү гэрээний дагуу шилжүүлэн өгсөн аливаа этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн хэргээс өөр өмнө үйлдсэн ямар нэг гэмт хэрэгт холбогдуулан саатуулах, яллах буюу шийтгэх, эсхүл аль нэг гуравдагч улсад дор дурдсанаас бусад тохиолдолд, ямар нэг гэмт хэргийн төлөө шилжүүлэн өгөхгүй. Үүнд:
 - а) шилжүүлэн өгсний дараа тухайн этгээд нь хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрийг орхин гарсан боловч сайн дураараа буцаж ирсэн бол;
 - б) тухайн этгээд хүсэлт гаргагч талын нутаг дэвсгэрийг дөчин тав (45) хоногийн дотор чөлөөтэй орхин гарах зөвшөөрөлтэй боловч ийнхүү орхин гараагүй бол;
 - в) хүсэлт хүлээн авагч тал зөвшөөрсөн бол. Ийнхүү зөвшөөрөл хүссэн хүсэлтэд энэхүү гэрээний 6 дугаар зүйлд дурдсан баримт бичиг болон тухайн гэмт хэрэгт холбогдож буй шилжүүлэн өгсөн этгээдийн нөхцөл байдлын талаар мэдээллийг хавсарган илгээнэ. Энэхүү гэрээний дагуу шилжүүлбэл зохих гэмт хэрэгт тус зөвшөөрлийг дөчин тав (45) хоногийн дотор өгч болно.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэг нь шилжүүлэн өгсний дараа үйлдэгдсэн гэмт хэрэгт хамаарахгүй.

16 ДУГААР ЗҮЙЛ

Дамжин өнгөрөх

1. Аль нэг гуравдагч улсаас нөгөө талд хүлээлгэн өгч буй аливаа этгээдийг талуудын аль нэгний нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх бол ийнхүү дамжин өнгөрүүлэх тухай хүсэлтийг дипломат шугамаар, бичгээр тавих бөгөөд тухайн талын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгоно.
2. Хэрэв дамжин өнгөрүүлэх талын нутаг дэвсгэрт газардалгүй, агаарын тээврээр шууд дамжин өнгөрөх бол дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл шаардахгүй. Хэрэв тухайн талын нутаг дэвсгэрт газардах шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаж болно.

17 ДУГААР ЗҮЙЛ

Үр дүнг мэдэгдэх

Хүсэлт гаргагч тал нь шилжүүлэн өгсөн тухайн этгээдийг ял шийтгэсэн, шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг хэрэгжүүлсэн, эсхүл түүнийг аль нэг гуравдагч улсад дахин шилжүүлсэн талаарх мэдээллийг хүсэлт хүлээн авагч талд тухай бүр мэдэгдэж байна.

18 ДУГААР ЗҮЙЛ

Төлөөлөл болон зардал

1. Хүсэлт хүлээн авагч тал гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлттэй холбогдуулан үүсэх аливаа шүүх ажиллагаанд хүсэлт гаргагч талын нэрийн өмнөөс шүүх хуралд оролцож, зөвлөж туслалцаа үзүүлэх бөгөөд түүний ашиг сонирхлыг төлөөлнө.
2. Хүсэлт хүлээн авагч тал шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт этгээдийг өөрийн нутаг дэвсгэрт баривчлах болон хүсэлт гаргагч талаас нэр заасан этгээдийг шилжүүлэх хүртэл баривчлах болон албадан саатуулахтай холбогдсон өөрийн нутаг дэвсгэр дээрх зардлыг хариуцна.
3. Хүсэлт гаргагч тал хүсэлт хүлээн авагч талын нутаг дэвсгэрээс гэмт этгээдийг шилжүүлэн гаргах болон дамжин өнгөрүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.



4. Хүсэлт гаргагч тал энэхүү гэрээний дагуу гэмт этгээдийг шилжүүлэх хүсэлтэд хавсаргаж хүргүүлэх баримт бичгийг орчуулах, тайлбарлах, хуулбарлах болон тухайн этгээдийг тээвэрлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.
5. Хэрэв зардал үлэмж их байвал талууд зардлыг хэрхэн хариуцах талаар зөвлөлдөнө.

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Зөвлөлдөх

Талууд энэхүү гэрээний үйл ажиллагааг дэмжихийн тулд эрх бүхий төв байгууллагаар дамжуулан тус гэрээг тайлбарлах, хэрэглэх болон хэрэгжүүлэх талаар харилцан зөвлөлдөнө.

20 ДУГААР ЗҮЙЛ

Маргаан шийдвэрлэх

Энэхүү гэрээг тайлбарлах, хэрэглэх болон хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа маргааныг талуудын эрх бүхий төв байгууллага харилцан зөвлөлдөж шийдвэрлэнэ. Хэрэв эрх бүхий төв байгууллагууд зөвшилцөлд хүрч шийдвэрлэх боломжгүй тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Олон улсын олон талт гэрээтэй харилцах

Энэхүү гэрээ нь талуудын нэгдэн орсон олон улсын гэрээ болон хоёр талт гэрээ, бусад хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн эрх, үүрэгт хамаарахгүй.

22 ДУГААР ЗҮЙЛ

Хүчин төгөлдөр болох, нэмэлт, өөрчлөлт оруулах болон цуцлах

1. Талууд энэхүү гэрээг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Энэхүү гэрээ нь хоёр мэдэгдлийн хамгийн сүүлд хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээнд харилцан зөвшилцсөний үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа нэмэлт, өөрчлөлт нь тус гэрээний хүчин төгөлдөр болсон арга замын дагуу хүчин төгөлдөр болно.



3. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болмогц 2000 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан “Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Монгол Улсын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-ний 54-69 дэх зүйлийн заалтууд хүчин төгөлдөр бус болно.
4. Энэхүү гэрээ нь тодорхой бус хугацаагаар хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Аль ч тал, хэдийд ч энэхүү гэрээг дуусгавар болгох тухай хүсэлтийг дипломат шугамаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болно. Гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдлийг нөгөө тал хүлээн авснаас хойш нэг зуун наяд (180) дахь өдрөөс дуусгавар болно. Гэрээ дуусгавар болох нь гэрээ дуусгавар болохоос өмнө эхэлсэн гэмт этгээд шилжүүлэх ажиллагаанд нөлөөлөхгүй.

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТОЛЖ, талуудын Засгийн газраас бүрэн эрх олгосны дагуу энэхүү гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү гэрээг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо вьетнам, монгол, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ
СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ЦЭНДИЙН НЯМДОРЖ
ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

**ТО ЛАМ
НИЙГМИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН САЙД**

МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХООРОНДЫН

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар нь (цаашид “Талууд” гэх)



Найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжихийг эрмэлздэгээ илэрхийлж,

Олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцэх, нийгмийн болон байгаль орчны хариуцлагад тууштай байр суурь сахихын чухлыг дурдан

Дараах зүйлсийг харилцан тохиролцов:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ДҮН, АГУУЛГА

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдол бүхий Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөлд зориулан Монгол Улсын Засгийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрөв.

Уг дэмжлэгийн нийт дүн болох 60,700,000 евро (жаран сая долоон зуун мянган евро)-оор дээр дурдсан энэхүү Хэлэлцээрийн хавсралтад агуулгыг нь нарийвчлан тодорхойлсон төслийн гүйцэтгэлийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Франц Улсаас францын бараа, үйлчилгээ худалдан авах;
- Олгосон санхүүгийн дэмжлэгийн 30 (гуч)-аас хэтрэхгүй хувийг монголын болон гуравдагч орны бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулах, холбогдох гэрээг францын гүйцэтгэгчийн хариуцлагын дор хэрэгжүүлэх.

2 ДУГААР ЗҮЙЛ – ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ХЭЛБЭР

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төслийг Бүгд Найрамдах Франц Улсын Төрийн сангийн зээлээр санхүүжүүлнэ. Хэлэлцээрийн хүрээнд францын талаас худалдан авах бараа, үйлчилгээг урьдчилан тохиролцсон Франц Улсын гүйцэтгэгчидтэй гэрээ шууд байгуулах аргаар бараа нийлүүлэх гэрээ (цаашид “гэрээ” гэх) байгуулан гүйцэтгэнэ.

Монгол Улсын болон гуравдагч орны бараа, үйлчилгээ худалдан авахад Монгол Улсын хуулийн дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр худалдан авалт хийнэ.

Гэрээ тус бүрийн санхүүжилтийн эхний хэсэг нь тээвэр, даатгалыг оролцуулалгүйгээр гэрээний үнийн дүнгийн 10-20 хувь байна.

3 ДУГААР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН НӨХЦӨЛ, ХЭЛБЭР

Францын Төрийн сангийн зээлийн хугацаа 40 жил бөгөөд үндсэн зээлийн төлбөрөөс эхний 12 жил чөлөөлөгдөнө. Зээлийн хүү жилийн 0.0076 хувь байна. Үндсэн зээлийг хагас жил тутам ижил хэмжээтэй, дараалсан 56 удаагийн төлбөрөөр эргүүлэн төлнө. Эхний төлбөрийг тухайн зээл олгогдсон улирал дууссанаас хойш 150 сарын дараа хийнэ (төлбөрийг

жил бүрийн 5 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 30-нд хийнэ). Хүүг үндсэн зээлийн үлдэгдэл дүнгээс бодох ба Францын Төрийн сангаас санхүүжилт олгосон огноо тус бүрээс эхлэн тооцож, хагас жил тутам төлнө.

Үндсэн зээл эсхүл хүү төлөх огноо нь Францад ажлын бус өдөр таарвал, төлбөрийг дараагийн ажлын өдөр хүртэл хойшлуулна. Хугацаандаа хийгдээгүй үндсэн зээлийн болон хүүгийн төлбөрт төлбөр хийх ёстой байсан өдрөөс эхлэн хийгдсэн өдөр хүртэл хугацаа хэтэрсний хүү тооцно. Хугацаа хэтэрсний хүүгийн хэмжээг Еврогийн богино хугацааны ханш (Euro Short-Term Rate буюу ESTER) дээр 4 хувийг нэмж тооцох ба энэ нь жилийн 5 хувиас багагүй байна. Хугацаа хэтэрсний хүүг бүтэн жилээр хожимдуулбал дээрх ханшаар хүүгийн хүү тооцно.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрыг төлөөлж Натиксис банк (банкийг төлөөлж Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлагын газар), Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам Зээлийн гэрээг байгуулна. Уг зээлийн гэрээнд Францын Төрийн сангийн зээлийг ашиглах болон эргэн төлөх хэлбэрийг тодотгож өгнө.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨЛБӨР, ТООЦООНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Энэхүү Хэлэлцээртэй холбоотой төлбөр, тооцооны мөнгөн тэмдэгт нь евро байна.

5 ДУГААР ЗҮЙЛ – ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Энэхүү Хэлэлцээртэй холбоотой гэрээ бүрийг байгуулахдаа дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- (i) Урьдчилсан байдлаар төсөлд хийсэн дүгнэлтээс гарсан зөвлөмжтэй гэрээ нийцэж байх;
- (ii) Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын дүрэм, журамтай төсөл нийцэж буй эсэхийг шалгасан байх;
- (iii) Монгол Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газартай байгуулсан өмнөх зээлүүдийн хувьд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
- (iv) Монгол Улсын Засгийн газарт эсхүл түүний аль нэг төрийн байгууллагад, эсхүл Монгол Улсын Засгийн газар баталгаа гаргасан этгээдэд олгосон Францын Засгийн газрын баталгаа бүхий хугацаандаа төлөгдөөгүй банкны зээлийн үлдэгдэл байгаа эсэхийг шалгасан байх;
- (v) Энэхүү Хэлэлцээрийн 6 болон 7 дугаар зүйлд заасан үүрэг амлалтын биелэлтийн нөхцөлийг хангах.

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ тус бүр дээрх нөхцөлүүдийг бүрэн гүйцэд хангаж байна гэж францын эрх бүхий байгууллага үзвэл, түүний зөвшөөрлийг үндэслэн Монгол дахь Францын Элчин сайдын яамны Эдийн засгийн албаны дарга Монгол Улсын



Сангийн яамтай захидал солилцсоноор уг гэрээ энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж эхлэх үндэс бүрдэнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ – АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Талууд энэхүү Хэлэлцээрийн оршилд олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцлийг дэмждэгээ илэрхийлсэн. Уг Хэлэлцээрийн хүрээнд гэрээ байгуулах талууд нь өөрсдийн болон өөр нэг талын ашиг сонирхлын тулд гуравдагч этгээдэд шууд болон шууд бус замаар хууль бус үйл ажиллагаа, авлига авах нөхцөлийг бүрдүүлж болохуйц шударга бус, мөнгөтэй холбоотой эсхүл бусад давуу талыг санал болгох, олгох, амлах, мөн түүнтэй адилтгах зүйлийг тэднээс шаардаж болохгүй.

Талууд 1 дүгээр зүйлд заасан төслийн хүрээнд авлигын аливаа үйлдэл бий болгохгүй байх үүрэгтэй. Талууд нь сэжиг бүхий нөхцөл байдлын талаар мэдмэгцээ харилцан мэдээлэх, нөхцөл байдлыг арилгахын тулд шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын сэтгэл ханамжид нийцүүлэх үүрэг хүлээнэ.

Дээр дурдсан үүргүүдийг биелүүлээгүй тохиолдолд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь өөрийн зүгээс хамгийн зохимжтой гэж үзэх гэрээ байгуулахаас татгалзах, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгохоор тохиролцсон санхүүгийн тусламжийн төлбөрийг түдгэлзүүлэх, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгосон санхүүжилтийг нийтэд нь эсхүл хэсгийг нь тохирсон хугацаанаас эрт төлөхийг шаардах эрхтэй.

7 ДУГААР ЗҮЙЛ – НИЙГМИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАРИУЦЛАГЫН ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Талууд нь Олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн байгаль орчны болон нийгмийн хэм хэмжээ, үүний дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйл мөн хүрээлэн буй орчны талаарх олон улсын конвенцуудыг, тухайлбал удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц, түүнчлэн Олон улсын санхүүгийн корпорацийн гүйцэтгэлийн стандартуудыг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжих шаардлагатайг санал нэгтэй зөвшөөрөв.

8 ДУГААР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХУГАЦАА

Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан санхүүгийн дэмжлэгийг авахын тулд францын гүйцэтгэгч болон монголын худалдан авагчийн хооронд гарын үсэг зурсан гэрээний эрх 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор нээгдсэн байна.

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олгож буй Францын Төрийн Сангийн зээлийн хөрөнгийг 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ашиглаж дууссан байна.

Шаардлагатай тохиолдолд, эдгээр хугацааг Талууд хоорондоо тохиролцож, захидал солилцох хэлбэрээр сунгаж болно.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТАТВАР, ХУРААМЖ

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олгож буй санхүүжилтийг Монгол Улсад ямар нэгэн татвар, хураамж төлөхөд ашиглахгүй.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Давхар татвараас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр”-т өөрөөр заасан байсан ч, уг Хэлэлцээрийн хүрээнд төлөвлөсөн санхүүжилтийг Монгол Улсын хөгжилд бүрэн ашиглах үүднээс Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төслийн хэрэгжилт, уг төсөлд олгосон санхүүгийн дэмжлэгийг эргүүлэн төлөхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа энэхүү Хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсны дараа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулах албан татвар, хураамж (онцгой албан татвар, гаалийн татвар болон НӨАТ)-аас чөлөөлөгдөнө.

Хэрэв Монгол Улсад мөрдөгддөг дүрэм, журмын дагуу агуулга, зориулалтаас үл хамааран зайлшгүй татвар, хураамж төлөхөөр болсон тохиолдолд түүнийг францын тал эсвэл францын компаниуд хариуцахгүй.

10 ДУГААР ЗҮЙЛ – ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар өөрийн зардлаар энэхүү Хэлэлцээрт тусгасан төслийн Монгол Улсын эдийн засгийн хөгжилд үзүүлсэн үр нөлөөг эдийн засаг, санхүү болон нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдээр гарган дүгнэж болно. Монгол Улсын Засгийн газар энэхүү судалгаанд оролцох, судалгааны үр дүнг шууд хүртэх боломжтой.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас томилсон дээрх судалгаа, дүгнэлт хийх шинжээчдийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг хүлээнэ.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү Хэлэлцээр нь Талууд түүний хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

12 ДУГААР ЗҮЙЛ – ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Энэхүү Хэлэлцээрт Талуудын бичгээр тохиролцсоныг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

13 ДУГААР ЗҮЙЛ – МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүдэн гарах аливаа маргааныг Талууд харилцан зөвлөлдөх, хэлэлцэх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.



Дурдсан заалтуудыг хүлээн зөвшөөрч хоёр улсын Засгийн газрын эрх бүхий төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурж тамгалав.

Улаанбаатар хот. 2020 оны 05 дугаар сарын 12

Монгол, франц хэлээр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.

**БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ФИЛИПП МЭРЛИН
БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСААС
МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ
БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР
САНГИЙН САЙД**

ХАВСРАЛТ

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олгож буй 60,700,000 евро (жаран сая долоон зуун мянган евро)-гийн санхүүгийн дэмжлэг нь Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийг таатай нөхцөлөөр санхүүжүүлэх зорилготой.

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төслийн бүрэлдэхүүн хэсгийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Улаанбаатар хотод дүүжин тээврийн замын эхний шугамыг Баянхошуу – Ханын материал – 3, 4 дүгээр хорооллын эцэс чиглэлээр барьж, ашиглалтад оруулах ба хоёр дахь шугамыг 7 буудал – Дарь эх – Сансарын тойруу гэсэн чиглэлд барихад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна (дүн дээд тал нь 35,400,000 евро).
- Хоёр дахь шугамын техник, эдийн засгийн үндэслэлээр тооцоолсон үнийн дүнг Франц болон Монголын эрх бүхий байгууллагууд баталсан тохиолдолд уг шугамыг барьж, ашиглалтад оруулна (дүн дээд тал нь 25,300,000 евро).

Энэхүү хавсралт нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.25

Индекс: 200003